MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,140.555... УСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.05.02. Мягмар. №086 (4700) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




УЛС ТӨР

Ж.БАТЗАНДАН: ЗӨРЧИЛД БАРИВЧЛАХ ЯЛ ОНООХ НЬ БУРУУ

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

НЭР ХҮНД ЯАХ ВЭ, ҮР ХҮҮХДҮҮДЭЭ Л БОДЬЁ

V нүүрт

Дугаарын 60 мөр

## Ашиг харахаас өөрийг мэддэггүй монголчууд

О.УЯНГА

Монголчууд бид цөөхүүлээ. Тийм болохоор нэг нэгээ муулж гоочлох биш, өргөж татаад хөгжмөөр байгаа юм. Гэхдээ л энэ улсад хэлэхгүй өнгөрч боломгүй олон асуудал бий. Тэрний нэг нь чанар, стандарт. Монголд чанар, стандарт гэж алга. Бүх зүйл дээр хэлсэн юм биш шүү. Үйлчилгээний чанарын талаар хөндөх гэж байгаагаа яаран сануулъя. Монгол Улс хөгжихгүй байна. Харин гишүүд баяжиж, баячууд нь улам хөрөнгөжиж, хотын төвд өндөр шилэн барилгууд ээлж дараалан баригдаж буйг бид бэлхнээ харж буй. Гэтэл хөдөө орон нутагт хөгжил гэж алга. Тэр дундаа Замын-Үүд. Гэтэл хэдхэн км-ын цаана байрлах Хятадын Эрээн гэж тосгон манай нийслэлээс илүү хөгжилтэй болох шахаж байна. Харин Замын-Үүд яав. Бахь байдгаараа. Ядаж тэнд олигтойхон боловсон 00 алга. Галт тэрэгний буудлынх 00 нь 300 төгрөгийн үнэтэй.

Үргэлжлэл нь III нүүрт

ДОТОР НҮҮРТ




Х.ЦАГААНБААТАРААР АХЛУУЛСАН “ЦАГААН БАРС” ИЛҮҮ БАЙЛАА 8

ҮЗЭЛ БОДОЛ

# ТАТВАР НЭМЭХ ХУГАЦААГАА ХОЙШЛУУЛААЧ

Н.ПУНЦАГБОЛД

Монголын түүхэнд хараар тэмдэглэгдэх өдөр байлаа, өчигдөр. Ийм дүгнэлтийг АН-ынхан хийсэн юм. Учир нь өчигдрөөс эхлээд хэд хэдэн татвар нэмэгдэж байгаа юм. Тэр дундаа автомашины татвар нэмэгдлээ. Татвар нэмэгдэх сураг гарснаас хойш буюу дөрөвдүгээр сарын дунд үеэс эхлээд л автомашины үнэ нэмэгдсэн. Өчигдрөөс бүр ч их нэмэгдэж эхэллээ. Машины ченжүүд өмнө нь татваргүй оруулж ирсэн машинуудаа хүртэл өндөр үнээр зарж байгаагаа нуугаагүй. Учир нь татвар нэмэгдээд ирэхээр машин оруулж ирээд ч зарагдахгүй, хэцүүдэнэ гээд байгаа юм. Өчигдөр АН-ынхан мэдээлэл хийхдээ Монголд жилд 36 мянган машин зарагддаг. Түүний 80-85 хувь нь хосолсон хөдөлгүүртэй, тэр дундаа приус байдаг хэмээн хэлсэн. Харин татвар нэмэгдэхээр приусны үнэ таван саяар өсөхөөр болчихлоо. Автомашины татварыг нэмснээр МАН-ынхан дундаж давхаргаа ядууруулах бодлого барьлаа гэдгийг ч тэд хэлж байсан. За тэр нь ч арай юу юм. Мэдээж тодорхой хэмжээнд иргэдийн нуруун дээр ачаа ирж байгаа. Гэхдээ түүнийгээ МАН-ынхан зөв тайлбарлаж чадахгүй байна. Сангийн сайд Б.Чойжилсүрэн ам ангайх болгондоо шахам “ОУВС-гийнхан тэг гэсэн. Ийм арга хэмжээ ав гэсний дагуу бид хийж байгаа” гээд л байсан. Бараг л ОУВС-гаас приусны татварыг хүртэл нэм гэж хэлсэн хэмээн хэлэх нь холгүй байлаа. Гэтэл өчигдөр АН-ын нарийн бичгийн дарга С.Эрдэнэболд гэдэг залуу ОУВС-гийн төлөөлөгч Нийл Сакерын хэвлэлд өгсөн ярилцлагыг иш татаж, ямар татвар нэмэхээ манайхан өөрсдөө шийдэж буйг ч хэллээ. Ингээд л дотооддоо, гадаадад ч онигоо болоод байна, бид. Хамгийн гол нь МАН-ынхан ОУВС-гийн “Санхүүгийн өргөтгөсөн хөтөлбөр”-т хамрагдахын тулд татвар нэмэхгүй бол болохгүй гэсэн. Улмаар долоон төрлийн татварын хэмжээг нэмсэн. Өчигдрөөс зарим татвар нь нэмэгдэж байгаа гэдгийг дээр дурьдсан. Тэгвэл ОУВС-гийнхан манайд хэрэгжүүлэхээр тохиролцсон хөтөлбөрөө хэрэгжүүлэх дээр унжиж эхэллээ. Өөрөөр хэлбэл, Олон улсын валютын сангийн Захирлуудын зөвлөл өнгөрөгч баасан гарагт хуралдаж, хөтөлбөрт хамрагдах Монголын хүсэлтийг хойшлуулчихлаа. Хэвлэлийнхний шуугиад байгаагаар бол “Рио Тинто” л ОУВС-гийнхныг эргэлзэхэд хүргэсэн юм байх. Монголын баялгийг олзворлож буй Оюутолгой мэтийн том төслийн төлбөр тооцоо, мөнгөн гүйлгээний зарим хэсгийг Монголын банкуудаар явуулах тухай заасан УИХ-ын тогтоол эгдүүг нь хүргэсэн юм байх. Энэ тал дээр АН, МАН гэлтгүй бүгдээрээ нэг байр суурьтай байж, бат зогсох хэрэгтэй гэж АН-ын бүлгээс өчигдөр мэдэгдсэн. Гэвч МАН-ынхан яахыг хэлж мэдэхгүй нь. Гэхдээ ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдах хугацаа тодорхой бус байдалд орчихоод байгаа учраас эрх баригчид татвар нэмэх асуудлаа эргэж харахгүй юм уу. Ядаж тавдугаар сарын 1-нээс эхлээд нэмэгдэж буй автомашины татварынхаа хугацааг хойшлуулах хэрэгтэй юм биш үү. ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдахын тулд татвар нэмэхээс өөр аргагүй байсан гэж итгэе, хамаагүй. Тэгвэл тэр хөтөлбөрт хамрагдах хугацаа чинь ядаж л хойшилчихлоо. Тийм болохоор татвар нэмэх хугацаагаа хойшлуулах хэрэгтэй биз дээ. Автомашинтай болох гэсэн иргэдийнхээ хэрэгцээг шаардлагыг бодсон ч. Автомашин оруулж ирж байгаа хүмүүсээ ч бодсон татвар нэмэхээ больдоггүй юм гэхэд ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдах нь тодорхой болох хүртэл хугацааг нь хойшлуулмаар байна.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## Л.ЦЭРЭНСОДНОМ: МОНГОЛ ХҮҮХДҮҮД ДЭЛХИЙН ХЭМЖЭЭНИЙ ЗАГВАР БҮТЭЭЖ, ӨРСӨЛДДӨГ

Дэлгэрэнгүй ярилцлагыг VII нүүрнээс

ТОМИЛОЛТ

## “Говийн чоно” сургалт, дадлага сургууль Монголын брэнд болж байгааг онцоллоо

Ч.ЧУЛУУН

Онцгой байдлын ерөнхий газраас АНУ-ын Номхон далайн командлалтай хамтран зургаа дахь жилдээ зохион байгуулж буй “Говийн чоно”-2017 олон улсын сургалт, дадлага сургууль өнөө өглөө Өмнөговь аймагт эхэлсэн. Сургуулийн нээлтийн арга хэмжээнд ОБЕГ-ын дарга, бригадын генерал Т.Бадрал, УИХ-ын гишүүн Д.Амарзаяа, АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн Эрхт Элчин сайд, хатагтай Женнифер Зимдал Галт, Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Наранбаатар нар оролцож үг хэллээ.

Үргэлжлэл нь III нүүрт




### ХААН банк

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2410.00 | 2426.00 | ФУНТ | 3076.00 | 3155.00 |
| ЕВРО | 2598.00 | 2665.00 | РУБЛЬ | 41.40 | 43.50 |
| ИЕН | 21.56 | 21.87 | ЮАНЬ | 348.30 | 351.50 |

### Худалдаа хөгжлийн банк

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2414.00 | 2426.00 | ФУНТ | 3088.00 | 3162.00 |
| ЕВРО | 2603.00 | 2669.00 | РУБЛЬ | 41.30 | 44.38 |
| ИЕН | 21.42 | 21.99 | ЮАНЬ | 349.00 | 351.90 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## Иргэн, судлаач, УИХ-ын хамтарсан ажлын хэсэг байгуулна

Анхдугаар Зөвлөлдөх санал асуулга өнгөрсөн амралтын өдрүүдэд Төрийн ордонд болж өнгөрсөн билээ. Тэгвэл энэ талаар УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцан, Г.Занданшатар, М.Оюунчимэг болон Зөвлөлдөх зөвлөлийн дарга Д.Ламжав нар өчигдөр мэдээлэл хийлээ. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Анхдугаар зөвлөлдөх санал асуулгын эхний шатанд 1570 хүн оролцсон. Үүнийг санамсаргүй түүврийн аргаар сонгосон бөгөөд хоёр дахь шатанд 740 төлөөлөл оролцсон юм. Эдгээр 740 хүнийг 15 гишүүнтэй 49 баг болгож, баталсан сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлсэн юм. Хоёр өдөр үргэлжилсэн энэхүү санал асуулгаас зөвлөмж гарах юм байна. Уг зөвлөмжийг энэ сарын 6 гэхэд Төрийн байгуулалтын байнгын хороонд хүлээлгэн өгөх төлөвлөгөөтэй байгаа аж. Үүний дараа Байнгын хороо УИХ-д танилцуулах юм байна. Улмаар иргэн, УИХ, шинжээч, судлаачдын хамтарсан Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгийг байгуулах аж. Тэрхүү ажлын хэсэг нь иргэдийн, Ерөнхийлөгчийн, Улсын дээд шүүхийн, Үндсэн хуулийн цэцийн саналыг тусгасан Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах юм байна.


MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.
2 давхар. 209, 211 тоот

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.


# Ж.БАТЗАНДАН:

## Зөрчилд баривчлах ял оноох нь буруу



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Н.БОЛД

УИХ дахь Ардчилсан намын бүлэг өчигдрийн хуралдаанаар Олон улсын валютын сан /ОУВС/-тай тохирсон "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-тэй холбоотой асуудлаар Сангийн сайдын мэдээллийг сонсох байсан ч Сангийн сайд ирээгүй байна. Тэгвэл бүлгийн хурлын дараа УИХ дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Эрдэнэбат "Өнөөдөр тавдугаар сарын 1. Татварууд нэмэгдэж байна. ОУВС ойлгомжгүй болсон өдөр. Өнөөдөр эрх баригчдын, Б.Чойжилсүрэн сайдын амлаад байгаа бүхэн ойлгомжгүй болж эхэллээ. Нэг л зүйлийг бид хэлж, сануулсан. Иргэдийнхээ халаас руу гар дүрж болохгүй шүү гэж. Гадны шахалтаар иргэдийг татварын дарамт руу хийж болохгүй гэдгийг өмнө нь бид сануулсан. Тэр үед эрх баригчид "ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдчих юм бол мөнгө олж ирээд өрийн дарамтаа багасгаад явчихна" гэж хэлсэн. Гэтэл өнөөдөр ойлгомжгүй байдалд орууллаа. Монгол Улсын тусгаар улс гэж ойлгодог, бид дотооддоо асуудлаа зөв шийдэх байтал маш ойлгомжгүй байдлаар гадны нөлөөллөөр оруулж ирж байгаа нь Монголд тустай зүйл биш юм. ОУВС Монголын асуудлыг хэлэлцэхээ хойшлуулсан нь УИХ-ын 29 дүгээр тогтоолын 11 зүйлд заасан заалттай холбоотой гэж ойлгосон. Түүнд "Гадаадын томоохон хөрөнгө оруулагчдын гадагшаа гаргаж зарсан баяжмалын мөнгийг Монгол банкаар дамжуулъя" гэсэн заалт байсныг зөв гэж харж байгаа. Тийм учраас энэ тогтоолын заалтыг УИХ дахь Ардчилсан намын бүлэг дэмжсэн. 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбоотойгоор дагаж гарсан тогтоол. Бид энэ асуудалд тодорхой байр суурь илэрхийлэх ёстой. Гэхдээ өмнө нь Сангийн сайдын мэдээллийг сонсоё гэж бодсон ч манай бүлгийн хуралдаанд ирсэнгүй. Энэ тогтоол хэрэгжих ёстой. Тэр байтугай баяжмалаар гарч байгаа алтыг ч Монголдоо оруулж ирэх ёстой. Монголбанк алтаа авах ёстой. Тэгж байж валютын ханшийг тогтвортой хадгалж чадна" гэлээ. Түүнээс гадна АН-ын бүлгийн хурлаар Зөрчлийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн төслүүдийг тус бүр хэлэлцсэн байна. Энэ талаар УИХ-ын гишүүн Ж.Батзандан "УИХ дээр Зөрчлийн тухай хууль хэлэлцэгдэж байна, энэ долоо хоногт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлнэ. Эдгээр нь хүний үндсэн эрхийг хязгаарладаг хуулиуд юм. Өнгөрсөн долоо хоногт Ардчилсан намын бүлэг Зөрчлийн тухай хуультай холбоотой зарчмын байр сууриа илэрхийлсэн. Анх Засгийн газраас оруулж ирсэн Зөрчлийн хуулийн төсөлд торгох, эрх хасах гэж байсан. Харин Байнгын хорооноос байгуулагдан ажилласан ажлын хэсэг баривчлах шийтгэл нэмж оруулж ирснээр зөрчил үйлдсэн хүний халдашгүй эрхэнд цагдаагийн байгууллага халдах, хүний үндсэн эрхийг зөрчих боломжийг нээж өгсөн. Үүнийг өөрчлөх саналыг УИХ дахь Ардчилсан намын бүлэг удаа дараа гаргасан. Ингэснээр 11 зөрчил дээр баривчлах шийтгэл оруулж ирснийг тав болгож бууруулсан. Одоогийн байдлаар дөрвөн зөрчил дээр баривчлах шийтгэл үлдсэн. Зөрчлийн хууль гэмт хэргийн шинжтэй хууль болж хувирч байна. Зөрчилд баривчлах ял оноох нь буруу. Торгуулийн хэмжээ өндөр байгаа. Хуулийн этгээдийг 200 сая төгрөгөөр торгоно гэж орж ирсэн. Үүнийг Ардчилсан намын бүлэг Зөрчлийн хуулиар далимдуулж, жирийн иргэдийг хоморголон баривчлах нүх сүв нээгдэж байна. Хүний үндсэн эрхэд халдах, боомилох хэрэгсэл болгож ашиглах гэж байна гэж үзэж байгаа учраас эсэргүүцэж байгаа, сайжруулж гаргах ёстой. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн төсөл мөн анх Засгийн газар болон өмнөх УИХ дээр барьж байсан байр суурийг эвдсэн шинжтэй байна. Тухайлбал, эрүүгийн хэрэг мөрдөн шалгагдаад шүүхэд шилжүүлсний дараа шүүх тухайн хэрэгт ял шийтгэл ногдуулах ёстой, гэм буруу нь нотлогдохгүй бол цагаатгах ёстой. Мөрдөн байцаалтад хэргийгбуцаадагбайжболохгүй. Гэтэл энэ хуулийн төслөөр коммунист эрх зүйн системээ үргэлжлүүлэх зорилгоор мөрдөн байцаалтад шүүхээс буцаадаг байхаар оруулж ирснийг эсэргүүцэж байна. Мөрдөн байцаалтад хэргийг буцаадаг байх юм бол хүний эрх дордоно. Шүүх хэргийг мөрдөн байцаалтад буцааснаар ялыг илүү хүндрүүлэх боломж гарч ирнэ. Цагдан хорих байранд гүйцэтгэхажиллагааявуулахаар оруулж ирсэн. Социализмын үеэс цагдан хорих байранд гүйцэтгэх ажиллагаа явуулдаг байсан бурангуй явдлыг таслан зогсоох ёстой. Хэрэг үүсгэхээс өмнө гүйцэтгэх ажиллагаа явуулдагийг халах ёстой. Харамсалтай нь, эрх баригч нам прокурорын зөвшөөрлөөр гүйцэтгэх ажиллагаа явуулж болно гэж оруулж ирсэн байна. үүнийг дэмжих боломжгүй. Энэ гурван асуудлыг өөрчлөөгүй цагт энэ төслийг хойшлуулах, нягтлах асуудлыг бүлэг тавих болно" хэмээн мэдэгдлээ.

> ...Бид энэ асуудалд тодорхой байр суурь илэрхийлэх ёстой. Гэхдээ өмнө нь Сангийн сайдын мэдээллийг сонсоё гэж бодсон ч манай бүлгийн хуралдаанд ирсэнгүй. Энэ тогтоол хэрэгжих ёстой. Тэр байтугай баяжмалаар гарч байгаа алтыг ч Монголдоо оруулж ирэх ёстой. Монголбанк алтаа авах ёстой. Тэгж байж валютын ханшийг тогтвортой хадгалж чадна" гэлээ...

## О.Магнай: М.Энхболд хоёр тэрбум төгрөгөөр сурталчилгаа хийлээ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Ардчилсан намын нарийн бичгийн дарга асан О.Магнай болон нарийн бичгийн дарга С.Эрдэнэболд нар өчигдөр намын байрандаа цаг үеийн асуудлаар мэдээлэл хийлээ. Тэд МАН-ын дарга М.Энхболд Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхлээгүй байхад сурталчилгаа хийсэн, долоо төрлийн татвар нэмсэн гэх мэт асуудлыг хөндсөн юм. Мэдээллийн эхэнд АН-ын нарийн бичгийн дарга асан О.Магнай "УИХ-аар концесстэй холбоотой асуудал батлагдаж гарсан. Долоон концессын нийт хэмжээ 744 тэрбум 90 сая төгрөг. Эдгээр концессын гэрээнүүд хийгдэхэд бэлэн болоод байгаа. Нэр бүхий хүмүүс концессын гэрээ зурж байгаа талд байна гэдэг нь нууц биш болсон. Ардчилсан нам үүнийг хулгай ил цагаандаа гарлаа гэж үзэж байна. Засгийн газрын гишүүд нь засгийн газартайгаа гэрээ хийж концесс авна гэдэг чинь байж боломгүй үйлдэл" хэмээн мэдэгдсэн юм. Мөн "Тун удахгүй ерөнхийлөгчийн сонгууль болно. Хуулиар сонгуулийн сурталчилгаа 21 хоногийн өмнө эхлэх ёстой гэж заасан. Гэвч УИХ-ын дарга М.Энхболд 10 гаруй телевизээр "Бүрэн зураглал" нэртэй нэвтрүүлгийг хийлгэн цацаж, хоёр тэрбум төгрөгийн зардал гаргасан сонгуулийн сурталчилгаа хийлээ. МАН-ын байдлаас харахад, өнгөрсөн сонгуулийн бөхийн холбооноос хүн дэвшүүлсэн энэ удаад уяачдын холбооноос хүн дэвшүүлэх нь гэсэн сэтгэгдлийг төрүүллээ. АН-ын зүгээс энэ асуудлаар Сонгуулийн Ерөнхий Хороонд хандана. Шударга шүүх гэж байдаг юм бол УИХ-ын дарга М.Энхболд нэвтрүүлэг цацаж сурталчилгаа хийснээр нэр дэвших эрхээ хасууллаа гэж дүгнэж байна" хэмээн мэдэгдсэн юм.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## УИХ-ын дарга Үйлдвэрчний эвлэлийнхэнтэй уулзлаа

Улсын их хурлын дарга М.Энхболд Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөллийг өөрсдийнх нь хүсэлтээр өчигдөр хүлээн авч уулзлаа. Уулзалтад МҮЭ-ийн холбооны ерөнхийлөгч Х.Амгаланбаатар, ерөнхий нарийн бичгийн дарга Г.Адъяа тэргүүтэй Үйлдвэрчний эвлэлийнтөлөөлөлоролцсонюм. Энэ үеэр МҮЭ-ийн холбооны ерөнхийлөгч Х.Амгаланбаатар "Улс орны эдийн засаг амаргүй байгаатай холбоотойгоор иргэдийн хөдөлмөрлөх эрх ашиг, цалин, орлого, ядуурал гээд санаа зовоосон олон асуудал урган гарч байна. Нийгмийн зөвшилцлийн гурван талт хэлэлцээрээ бид энэ оны нэгдүгээр сард баталж, цалин нэмэх асуудлыг 2018 оны төсөвт тусгах, татвар нэмэхгүй байх зэрэг хэд хэдэн асуудлыг тусгасан. Гэтэл ОУВС-тай хамтран хэрэгжүүлэх хөтөлбөрийн нөхцөлийн талаар Засгийн газар МҮЭ-ийн холбооны санал бодол, байр суурийг огт сонссонгүй. Эцэст нь хэлэлцээрийн хүрээнд хөдөлмөрийн хамтын маргаан үүсэх нөхцөл бүрдлээ" хэмээсэн юм.

Тэгвэл УИХ-ын дарга М.Энхболд "2016 оны жилийн эцсийн болон энэ оны эхний улирлын төсвийн орлого давж биеллээ. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдсэн дүн гарсан. Валютын ханш харьцангуй тогтвортой байна. Энэ эерэг өөрчлөлтийг тогтвортой хадгалж, цаашдын өсөлтийг хангах нь бидний гол зорилго болж байна. Ингэхийн тулд ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдахаас өөр аргагүй нөхцөл байдал үүссэн. Бидэнд дотоодын ойлголцол, тогтвортой байдал нэн эрхэм байгааг та бүхэн ойлгож байгаа гэдэгт найдаж байна" хэмээсэн байна.

## Орон нутгийн сонгуулийн хорооныхонд зориулж сургалт зохион байгуулав

Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хороо Аймаг, нийслэл, дүүргийн сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга нарт зориулж Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах асуудлаар нэгдсэн сургалт-семинарыг өчигдөр хийлээ. Сургалт-семинарыг нээж Сонгуулийн Ерөнхий Хорооны дарга Ч.Содномцэрэн сонгуулийг зохион байгуулахдаа хууль, журмаа сайтар судлан, хуулиа дээдлэх, ил тод байдлыг хангах, шударга ёсыг сахих, Үндсэн хуулиар иргэдэд олгогдсон сонгох, сонгогдох эрхийг нь эдлүүлэхэд анхаарч, сонгогчдыг сонгуульд оролцож саналаа өгөх нөхцөл бололцоог нь бүрдүүлж ажиллах, хуваарилсан төсвийг хууль, журмын дагуу зориулалтаар нь захиран зарцуулахыг сануулсан байна.

Түүний дараа сонгуулийн хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, сонгуулийн гомдол, маргааныг хянан шийдвэрлэх, санал авах ажиллагааг зохион байгуулах, ажиглах, сонгуулийн дүн мэдээ нэгтгэх, техникийн тооллого хийх, сонгуулийн баримт бичиг хүлээлгэн өгөх, санал авах, тоолох ажиллагаанд автоматжуулсан систем ашиглах зэрэг асуудлаар оролцогчдод мэдээлэл өгчээ. Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулах аймаг, нийслэлийн 22 сонгуулийн хороо, сум, дүүргийн 339 сонгуулийн хороо, нийт 2078 хэсэг байгуулагдаад байна.

Дугаарын 60 мөр

# Ашиг харахаас өөрийг мэддэггүй монголчууд

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Зорчигчид нь бие засахаар болбол 300 төгрөгөө төлж байж орно. Ийм зүйл байж болох уу энэ чинь. Цаашлаад, галт тэрэгний буудлын ойролцоо, төв талбайн хажууд тоосгоор барьсан нийтийн бие засах газар байна билээ. Нэг удаа орж бие засахад 400 төгрөг. Манайх өртөг өндөртэй улс болчихоод байгаа нь үнэн. Гэхдээ бие засах газар 400 төгрөгийн үнэтэй байна гэдэг арай л өндөр биш үү. За яахав, үнэ дүүрч, цэвэрхэн, сайхан, тохилог байвал хамаа алга. Ер нь чанартай, сайн үйлчилгээтэй бол хүмүүс үнэ өртгийг нь асуудал болгоод байдаггүй. Харин 400 төгрөгийн үнэтэй бие засах газар заваан гэж авах юмгүй. Үнэр танар нь арай дэндүү. Орсон хүний дотор муухайрч, нүд хорсмоор. Ядаж байхад ганц хоёр хүж асаагаад, эсвэл арц уугиулчихаж болно доо. Тийм ч юм байхгүй. Цаашлаад гадна талаас нь харахад авах юмгүй. Нурж унах шахсан улаан тоосгон байшинцар л харагдаж байгаа юм. Тэр бие засах газарт өдөртөө 200 хүн ордог гэж тооцъё. Хамгийн багаар л бодоход шүү дээ. Хятад, монгол хүмүүс хоёр тийшээ хөлхөж буй газар үүнээс ч олон хүн орох боломжтой. Зүгээр л багаар тооцоод үзье. Ингэхэд л өдөртөө 80 мянган төгрөг шууд олно. Сардаа 2.4 сая төгрөг. Ийм хэмжээний мөнгөөр арц, хүж аваад байж дийлнэ дээ. Тэр битгий хэл гурван сардаа муудсан суултуураа солиод байсан ч болохоор. Мөнгөө жаахан цуглуулж байгаад гадна талыг нь өөд нь татаад, хэн ч харсан аятайхан байхаар засаж ч болно.

Гэтэл өмхий самхай нь дэндсэн бие засах газар ажиллуулаад, тэгсэн мөртлөө 400 төгрөг хураагаад сууж байна. Замын-Үүдийн засаг захиргаа, дарга гэж байдаг л байх. Энэ мэтэд анхаарал тавьж, стандартын шаардлага өгөх хэрэгтэй. Зарим хүмүүс бие засах газар юм чинь өмхий үнэртэж, шээс ханхалж л таараа. Гаднаасаа ямар ч харагдсан яадаг юм гэж хэлж магадгүй. Гэтэл манайх хил орчмын аялал жуулчлал хөгжүүлнэ гээд л байгаа. Зөв хийж чадвал бага ч болов ашиг олох л ажил. Гэтэл гаднаас жуулчид ирлээ гэж бодъё. Бие засах газар ч байхгүй байвал юун аялал жуулчлал хөгжүүлэх вэ. Тэр битгий хэл Эрээн явж байгаа монголчууд хүртэл сампирсан бие засах газраар орохгүй. Аргаа барахдаа орно гэж тооцдог юм уу, хаашаа юм. Ядаж л энэ мэтээсээ эхлээд өөд нь татаж, стандартай болгомоор байна. Тэгэхгүй бол зарим нь үнэтэй, сампирсан 00-д орохгүй гээд хаана ч хамаагүй сариад л явж байгаа. Ядаж л ил задгай бие засахаас сэргийлэхийн тулд, цаашлаад хүмүүст боловсон үйлчилгээ үзүүлэхийн тулд өөд нь татах хэрэгтэй биз дээ. Харамсалтай нь манайхан ашгаа л харна уу гэхээс өөр зүйл бодохгүй байна. Өрөвдөлтэй ч юм аа даа. Хэзээ бид хөгжинө дөө.

# Р.АМАРЖАРГАЛЫГ ДЭМЖСҮ



Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль хаяанд ирээд улстөрийн намууд Ерөнхийлөгчид нэр дэвших хүнээ тодруулах гэж байна.

Ардчилсан намаас гэхэд хэд хэдэн хүн л нэрээ дэвшүүлээд байна.

Бүгд л манай нэртэй улстөрчид байна аа ...

Гэхдээ бид хэнийг нь сонгох вэ гэдэг талаар ултай бөгөөд нухацтай бодох хэрэгтэй юм.

Нам дотроосоо урцалдаж байгаад нэгийг гаргалаа гэхэд цаана нь түүн лүгээ өрсөлдөх "мөст даваа" бий. Хальтарч ч магадгүй. Хальтаргаж магадгүй. Магадгүйгээр ч барахгүй.

Гэтэл хэн нь хальтрахгүй тэр давааг даваад гарах чансаа чадалтай вэ?

Нийт ард түмний дотор нэр хүндтэй, итгэлийг нь даах, ноён нуруутай, оюуны хирц, сэтгэлийн хаттай, эзэн богд Чингис хааны айлдснаар "гадас болж төрийг бэхлэн сахиж, аргамж болж улсыг барин хатуужих" тийм л хүн Монгол Улсын Ерөнхийлөгч болох ёстой юм даа.

Тийм ээ, эх орон, элгэн түмнээ юуны өмнө боддог зөв хүнийг л сонгох хэрэгтэй.

Тийм хүн гэвэл Амаржаргал л байх шиг ээ. Би Амаржаргалыг сайн танихгүй, мэндийн зөрөөтэй л явдаг. Гэхдээ энэ хүний улстөрчийн хувьд ярьж хэлж, хийж үйлдэж байгааг нь молхи би ажиглаж суудаг юм аа.

Үнэндээ молхи би Р.Амаржаргал, Д.Бямбасүрэн хоёрын TV - гээр ярьж байгааг нь бүрэн сонсдог юм.

Р.Амаржаргал өөдөө гарч иржч үзлээ, огцорч ойчиж ч үзлээ. Сонгогдож ч үзлээ. Сонгогдохоос татагалзаж ч үзлээ.

Эдгээрийн альалинд бардамнаж сайрхдаггүй, гутарч гунидаггүй хүн харагддаг. Улстөрийн хат, сэтгэлийн хат гэж энэ байх аа.

Хэдийгээр тэрбээр өөрийгөө таниулах гэж нэг их цоролзоод байдаггүй ч ард түмэн түүнийг үгүйлдэг юм байна лээ. Үүнийг би өнгөрсөн сонгуулийн үеэр л мэдсэн юм.

"Амаржаргалыг яагаад дэвшүүлсэнгүй вэ?" гэсэн харууслын үг олон түмний амнаас нэлээд унаж байхыг би сонссон. Тэр байтугай МАН - ыг дэмжигч зарим өвгөд хөгшдийн амнаас. Энэ бол нэг үг шүү!

...Нийт ард түмний дотор нэр хүндтэй, итгэлийг нь даах, ноён нуруутай, оюуны хирц, сэтгэлийн хаттай, эзэн богд Чингис хааны айлдснаар "гадас болж төрийг бэхлэн сахиж, аргамж болж улсыг барин хатуужих" тийм л хүн Монгол Улсын Ерөнхийлөгч болох ёстой юм даа...

Тэгээд тэрбээр хэний ч, өөрөөр хэлбэл, өөрийн, хүний удирдлагын алдааг зоригтой шүүмжилж чаддаг.

Тэднээс тэс өөр үзэл баримтлалтай байгаагаа хулчигнан нуудаггүй, бардам хэлж чаддаг юм билээ. Энэ нь зарим улстөрчийн сэтгэлд үл нийцэх авч гадны ямар ч нөлөөнд орохгүй байж чадах шударга улстөрч гэдгийг харуулна.

Өөрөөр хэлбэл, намын эрх ашиг гэж явцуурах бус, Монголын эрх ашгийг дээдлэх хүн гэдэг нь харагдаад байдаг. Энэ бол улстөрч хүний ноён нуруу л даа.

Мөн тэр бол эдийн засагч мэргэжилтэй, тэр дотроо зах зээлийн эдийн засгийн шаггүй мэдлэгтэй, улс орноо хямралаас гаргах арга нь "гуйлга" биш гэдгийг олж харсан хүн юм гэдгийг би TV - гээр хэлж ярьж байснаас нь мэдсэн юм.

Тийм ээ, манай төр "арван ембүү харахаар алгаа тосдог аав", ембүү харагдаагүй ч алгаа тосдог аав шиг ажиллаж болохгүй, өөрийн оюунаа ухаж, тархиа уудлан ажиллабал гадны царай харахгүйгээр хөл дээрээ амархаан босох тухай Та бид түүний ярьж байсныг бахархан чагнаж байлаав шүү.

Одоо манай монгол хэлэнд "оюунлаг" гэж нэг нэр томъёо орж иржээ. Тэгвэл би тэр нэр томъёог Амаржаргалд хамааруулах гээд байна л даа.

Арестотель, Күнз зэрэг эртний философчдын төр барихын ухааныг судалдаг гэдгийг нь би бас гадарлах юм аа. Яаж мэдсэн юм гэвэл өчүүхэн миний тэр тухай бичсэн зүйлийг уншчихсан, эдгээрийн бүр эртний монгол орчуулгууд нь бий юу гэж асуугаад, би англи, орос хэлээр нь үздэг юм гэж хэлж байсан.

Одоо Күнз, Арестотель, Гегелийг судалдаг улстөрч манайд ер Амаржаргалаас өөр бий болов уу? Оюуны хирц гэж энэ байх аа.

Мөн түүнд офшор ч гэх юм уу, авилгал гэх ч юм уу, фракц ч гэх юм уу тийм "сүүл" байхгүй цэвэр улстөрч байх аа.

Амаржаргалын тухай Та бид мэдэж байгаа минь ердөө л энэ юм.

Намынхан нь түүний өөр өөр авууштай чанарыг мэдэж байгаа биз ээ.

Зөвхөн намынхнаар нь тогтохгүй!

Учир иймийн тул Ардчилсан намын гишүүд фракц энэ тэрийг умартаж, Р.Амаржаргалыг санал нэгтэйгээр дэвшүүлэн гаргаж, Ерөнхийлөгчийн сэнтийд өрсөлдүүлнэ хэмээн найдан уриалж байна.

Ардчилсан намынхан дуугарвал дуу нэг дугтарвал хүч нэг байвал л сонгуульд ялна даа!

Ардчилсан намын гишүүн биш
боловч Монголын ардчиллын
төлөө дотроо үхэж явдаг Өвгөн
Хатагины Го.АКИМ
*(Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн, утга зохиолын доктор, профессор)*

ТОМИЛОЛТ

# "ГОВИЙН ЧОНО" СУРГАЛТ, ДАДЛАГА СУРГУУЛЬ МОНГОЛЫН БРЭНД БОЛЖ БАЙГААГ ОНЦОЛЛОО

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**



Энэ удаагийн "Говийн чоно-2017" олон улсын сургалт, дадлага сургуульд Монгол Улс, АНУ-ын оролцогчдоос гадна Япон, Непаль, Өмнөд Солонгос, Турк, Канад, Унгар, Бангладеш улс, НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар, Хүүхдийн сан, Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Дэлхийн зөн, Жайка, Японы хүүхдийг ивээх сан, Мерси кор, Олон улсын Улаан загалмайн-Улаан хавирган сар нийгэмлэг, Монголын Улаан загалмайн нийгэмлэг зэрэг байгууллагын нийт 210 гаруй төлөөлөл оролцож байна. ОБЕГ-ын дарга, бригадын генерал Т.Бадрал хэлсэн үгэндээ, "Говийн чоно-2017" зургаа дахь удаагийн олон улсын сургалт, дадлага сургуулийг Монгол Улсын Онцгой байдлын байгууллага, АНУ-ын Номхон далайн командлалтай хамтран анх удаагаа өмнөд бүсийн төв Өмнөговь аймагт зохион байгуулж байна.

Өмнөх таван удаагийн "Говийн чоно" сургалтууд нь Монгол Улсад тохиолдож болзошгүй газар хөдлөлтийн, гамшиг, төмөр замын тээврийн болон уул уурхайн ослын хор уршгийг арилгах, хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх, олон улсын хүмүүнлэгийн тусламж хүлээн авах, гамшигтай тэмцэх төлөвлөлтийг боловсронгуй болгох, бэлэн байдлыг сайжруулах зорилготой зохион байгуулагдаж бидэнд сургамж, туршлага, түүх болж үлдсэн.

"Говийн чоно" сургалтын хүрээ жилээс жилд өргөжиж, олон улсын түвшинд хүрч, гадаад улс орон, олон улсын байгууллага, оролцогчдын тоо жилээс жилд өсч, гамшгаас хамгаалах сургалт, дадлагын хувьд бас нэг Монгол бренд болж байна.

"Говийн чоно-2017" сургалт, дадлага сургууль нь өмнөх сургалт, дадлагуудаас хэд хэдэн зүйлээр онцлогтой юм. Тухайлбал, тус дадлага сургууль нь энэ жил "Мэдлэгээ түгээе, туршлагаа хуваалцъя" уриан доор зохион байгуулагдаж, оролцох гадаад улс орон, олон улсын байгууллагын тоо нэмэгдлээ. Анх удаагаа "Говийн чоно" сургалтыг өмнөд бүсийн төв Өмнөговь аймагт зохион байгуулж байгаа төдийгүй өмнөд бүсийн Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Баянхонгор, Өвөрхангай аймгуудын Онцгой комисс, орон нутгийн гамшгаас хамгаалах албад оролцож байна хэмээн онцлон дурдлаа.

Мөн тэрбээр, "Говийн чоно-2017" сургалт, дадлага сургуулийг зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн аймгийн Засаг дарга, удирдлага болон сургалт, дадлага сургуулийн бэлтгэл ажлыг мэргэжил арга зүйн зөвлөмжөөр ханган ажиллаж байгаа Онцгой байдлын ерөнхий газар, хошууч Т.Мортон ахлагчтай АНУ-ын цэргийн багийн ажлын хэсэгт талархал илэрхийлье. Сургалт, дадлага сургуульд оролцож байгаа та бүхэн мэдлэгээ нэмэгдүүлэх, сурч мэдэхийг хичээх, харилцан туршлага солилцох, хамтын ажиллагааг дээшлүүлэх, бэлэн байдлыг нэмэгдүүлэх, үр дүнтэй байх талаар хичээж оролцохыг хүсье" гээд олон улсын сургалт, дадлага сургуульд оролцохоор ирсэн Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд, гадаад улс орны цэргийн төлөөлөл, Олон улсын байгууллагын оролцогчид, Өмнөд бүсийн удирдлагууд, Онцгой комиссын гишүүд, Гамшгаас хамгаалах албад, Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн, ард иргэдэд баярласнаа илэрхийлж сургуулийн үйл ажиллагаанд амжилт хүслээ.

Сүүлийн жилүүдэд говийн бүсэд газар хөдлөлтийн чичирхийлэл нэмэгдэж байгаа. Тухайлбал, 2016 оны 11 дүгээр сард Өмнөговь аймгийн Цогтцэций суманд 24 цагийн дотор 0.7-3.8 магнитудын хүчтэй 52 удаагийн газар хөдлөлт чичирхийлэл мэдрэгдсэн.

Мөн тус аймагт уул уурхайн ослууд их тохиолдох болсон байна. Тиймээс "Говийн чоно-2017" олон улсын сургалт, дадлага сургуулиар газар хөдлөлтийн гамшгийн голомтод эрэн хайх, аврах, нэрвэгдэгсдийг хээрийн эмнэлэгт эмчлэх ажиллагаа, малын гоц халдварт өвчинтэй тэмцэх үеийн хээрийн эмнэлэг дэлгэх, Даланзадгад сумын ард иргэд аюулгүй цэгт цугларах, нүүлгэн шилжүүлэх дадлага, Цогтцэций суманд уурхайн ослын хор уршгийг арилгах, ард иргэдийг нүүлгэн шилжүүлэх зэрэг тактикийн үзүүлэх сургуулийг зохион байгуулах юм.



Реклам, зар сурталчилгааны алба: **99173710**

# УЛС ТӨР




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

...Энэ үеэр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр жагсаалд оролцож, өөрийн байр суурийг илэрхийлсэн юм. Тэрбээр "Хуримтлал хадгаламж гэдэг үг мөрөөдөл болсон нь үнэн. Хоёрдугаарт тэтгэврийн насыг шатлалтай нэмэх зайлшгүй шаардлага гарсан...

## Н.НОМТОЙБАЯР: ОРИЛЖ ХАШГИРАХААС ИЛҮҮТЭЙ ХАМТДАА ШИЙДЭХ ГАРЦ ГАРГАЛГААГ ОЛЪЁ

Н.БАТЗАЯА

Ирэх дөрвөн жилд Монголын ард түмэн бүсээ чангална. Цалин хөлс, санхүүгээс гадна хөдөлмөрийн чадвараараа ч бүсээ чангалж, улам л хичээх шаардлагатай болж буй тухай өдөр бүр хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярих болсон билээ. Учир нь Монгол Улсын Засгийн газар ОУВС-ийн өртгөсөн хөтөлбөрт хамрагдсанаар хүүхдийн мөнгийг бүлэгт үргэлжлүүлэн олгоно, цалинг ирэх дөрвөн жилд нэмэхгүй, шатахууны онцгой албан татварын өмнөх бууруулалтыг буцаах, хувь хүний орлогын албан татварыг шатлалтайгаар нэмэгдүүлэх, НДШ, ЭМДын шимтгэлийг 2018 оноос тус бүр нэг хувиар нэмэгдүүлэх зэрэг долоон төрлийн татварыг нэмэгдүүлнэ. Тэр бүү хэл тэтгэврийн насыг нэмэх шийдвэр гаргасан. Тодруулбал, тэтгэврийн насыг 2027 он гэхэд 60, 65 болгох юм. Тэгвэл Засгийн газраас гаргасан энэхүү шийдвэрийг иргэд эсэргүүцэж, Сүхбаатарын талбайд жагслаа. Энэхүү жагсаалыг Олон улсын хөдөлмөрчдийн эв санааны өдрийг тохиолдуулан МҮЭ-ийн холбооноос зохион байгуулсан бөгөөд 21 аймгийн төв талбайд 12-16 цагийн хооронд тайван жагсаал болж буй талаар жагсаалд оролцогчид онцлов. Жагсаалд оролцогчид Засгийн газраас долоон төрлийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг нэмэгдүүлэх, тэтгэврийн насыг нэмэгдүүлэх шийдвэрийг эсэргүүцэж буйгаа илэрхийлэн "Эрх ашгаа хамгаалъя" тайван жагсаал хийсэн юм. Тэд энэ үеэр тэтгэврийн насыг нэмэгдүүлснээр уул уурхай, төмөр зам, авто зам зэрэг салбарын хүнд нөхцөлд ажилладаг иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй гэдгийг хэлж байлаа. Жагсаалыг нээж, МҮЭХ-ны ерөнхийлөгч Х.Амгаланбаатар "Засгийн газар 2017 оны нэгдүгээр сард байгуулсан Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн улсын гурван талт хэлэлцээрийн заалтыг зөрчиж энэхүү цуглааныг зохион байгуулах нөхцлийг бий болгосон.

Засгийн газар ОУВС-тай хамтарч эдийн засгийн хүндрэлээс гарахын тулд өргөтгөсөн санхүүжилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ нийгмийн даатгалын шимтгэлийг нэмэгдүүлэх, долоон төрлийн татварыг нэмэх, тэтгэврийн насыг үе шаттайгаар нэмэгдүүлэх зэрэг олон чухал заалтуудыг зөрчиж ОУВС-тай урьдчилсан тохиролцоо хийж, УИХ-д өргөн барьж 2017 оны төсвийн тодотголыг олны хүчээр хүч түрэн батлуулж чадсан. Иймд МҮЭХ Монгол Улсын Засгийн газраас гурван сарын өмнө байгуулсан хэлэлцээрээ биелүүлэхийг шаардаж байна. Ард иргэдийнхээ амьдралыг доройтуулан байж ОУВС-тай хамтрах шаардлагагүй гэж үзэж байна. Иймд УИХ, Засгийн газарт ОУВС-тай хамтарч эдийн засгийн хүндрэлээс гарахын тулд өргөтгөсөн санхүүжилтын хөтөлбөрөө эргэн харах шаардлагыг хүргүүлнэ" гэв. Түүнчлэн жагсаалд оролцогчид "250 хоног ар гэрээсээ хол хүнд хортой нөхцөлд илүү цагаар ажилладаг", "Идэжуух нь дутаад ирэхээр эдийн засгаа үүрч яваа ажилчдынхаа халаасыг хоослох боловсон дээрмийг эсэргүүцэж байна", "Эрчим хүчний салбарын ажилтан бид татвар нэмэхийг эсэргүүцэж байна" "УИХ-аас гаргасан шийдвэрээ буцаахгүй бол бид тэмцлийн хурц хэлбэрийг сонгоно" зэрэг уриа лоозон барьж, эрх ашгаа хамгаалж байлаа. Энэ үеэр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр жагсаалд оролцож, өөрийн байр суурийг илэрхийлсэн юм. Тэрбээр "Хуримтлал хадгаламж гэдэг үг мөрөөдөл болсон нь үнэн. Хоёрдугаарт тэтгэврийн насыг шатлалтай нэмэх зайлшгүй шаардлага гарсан. Энэ бүхнийг хувь хүнд өгөөжтэй байх үүднээс эдийн засгийн арга замаар энэ намрын чуулганаар шийдье гэж байгаа юм. Хуульд заасан тэтгэврийн нас, түүнээс хойш тэтгэврээ тогтоолгоход өндөр хувиар тогтоогддог байх, хийж байсан ажил мэргэжлээс нь шалтгаалж тогтоодог байх, хөдөлгөөнт хөдөлмөр эрхэлж байсан оффисын ажил эрхэлж байсан хүмүүсийн тэтгэврийг заагтай тогтоодог байх ажлуудыг хийхээр ажиллаж байна. Засгийн газар байгуулагдснаас хойш 56 орчим тэрбум төгрөгийн тэтгэвэр даатгалтай холбоотой өрийг илрүүлсэн. Та бүхэнд загнуулах зүйл хийсэн гэдгээ сайн ойлгож байна. Хамгийн гол нь соёлтой шаардахыг хүсье. Орилж хашгирахаас илүүтэй хамтдаа шийдэх гарц гаргалгааг олъё. Түүнээс биш энэ жагсаалыг үймүүлэх хэрэггүй юм шүү. Та нарын бухимдалтай байгааг ойлгож байна. Амьдралд нь болж бүтэхгүй байгаа бүхэн та бүхнийг өнөөдөр Сүхбаатарын талбайд хөтөлж авчирсныг маш сайн ойлгож байна. Тиймээс гурван талт хамтын хэлэлцээрээр асуудлыг шийдвэрлэхээс өөр гарц гэж байхгүй ээ. Жагсаал цуглаанаас үүдэлтэй шаардлагыг би гардаж авна. Тиймээс нөгөөдөр өглөө яаманд дээр 09.00 цагаас МҮЭ-ийн ерөнхийлөгчийг та бүгдийн төлөөлөл болгож хамтдаа ширээний ард сууж асуудлаа хэрхэн шийдвэрлэх талаар ярилцъя. Ажил хэрэгч байдлаар тулгамдаж байгаа асуудлыг хамтдаа шийдвэрлэхийг хүсье" гэв. Мөн жагсаалд оролцогчид салбарын сайдаа уул уурхайн ажилчдын нэг өдөртэй танилцахыг урьсан юм.

ММ-ИЙН ТОДРУУЛГА

## В.Цэнд-Аюуш: Е баримтын нууц үгээ мартсан тохиолдолд 131313 дугаар ? тэмдэг илгээж сэргээж авах боломжтой

Н.АЛТАН

*Сүүлийн үед иргэдээс Татварын үйлчилгээний төвийн 1800-1288 дугаар холбогдохгүй, ebarimt.mn сайт ажиллахгүй байгаа болон иргэд хүссэн мэдээллээ авч чадахгүй байгаа талаар гомдол ирүүлэх болсон билээ. Энэ талаар Татварын ерөнхий газрын харьяа Татварын үйлчилгээний төвийн Татварын улсын ахлах байцаагч В.Цэнд-Аюушаас тодруулллаа.*

**-Сүүлийн үед Татварын үйлчилгээний төвийн 1800-1288 дугаар холбогдохгүй, иргэд мэдээлэл авч чадахгүй байна хэмээн гомдол гаргах боллоо. Энэ талаар тодруулахгүй юу?**

-Манай төвийн 1800-1288 дугаар ачаалал ихтэй ажиллаж байгаа нь үнэн. Энэ утсанд өдөрт дунджаар 1500-2100 гаруй иргэн, татвар төлөгчид хандаж байгаа. Үүнээс 700-800 гаруй иргэн нь л нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголт, урамшууллын талаар зөвлөгөө, мэдээлэл авдаг. Уг дугаарын утсанд холбогдсон иргэдэд нэмэгдсэн өртгийн албан татвар болон Е-баримтын талаар дунджаар нэг хүнтэй 4-6 минут ярьж заавар, зөвлөгөө өгч байгаа болохоор дараагийн иргэн холбогдтол түр хүлээнэ үү гэсэн горимд шилжиж холбогдож чадахгүй байх тохиолдол гардаг.

**-1800-1288 дугаарын төлбөр хэд вэ?**

-1800-1288 дугаарт холбогдоход иргэдийн ашигладаг үүрэн телефоны нэг минутийн яриа энгийн тарифаар тооцогддог.

**-Иргэд ямар шалтгаанаар НӨАТ-ын буцаан олголтоо авч чадахгүйд хүрч байна вэ?**

-Иргэд sugalaa.ebarimt.mn, butsaalt.ebarimt.mn, ebarimt.mn цахим сайтад хандаж сонирхсон мэдээллээ авах, мөн Татварын албаны mta.mn сайтын "Татварын боловсрол" цэсний Асуулт хариултын сангаас татварын хууль тогтоомж болон Е баримттай холбоотой мэдээллийг авах боломжтой. 2016 оны НӨАТ-ын буцаан олголтыг олгох үеэр ebarimt.mn сайтад нэг иргэн олон хэрэглэгч үүсгэсэн, хэрэглэгчийн мэдээлэл буруу, дутуу бөглөсөн тохиолдлууд их гарсан. Үүнийг засч залруулах ажил хийгдэж байгаа. Энэ асуудалтай холбоотой ebarimt.mn системд хэрэглэгчийн нэг бүртгэлүүсгэхзорилгоор131313 тусгай дугаараар төлбөрийн баримтаа бүртгүүлэхтэй холбоотой өөрчлөлтийг оруулсан. Тодруулбал, гар утаснаас 131313 тусгай дугаарт анх удаа баримтаа бүртгүүлснээр ebarimt.mn-д шинээр хэрэглэгч болж байсан бол одоо боломжгүй болсон. Заавал ebarimt.mn сайтад имэйл хаягаар бүртгэл үүсгэж, мэдээллээ бүрэн бөглөх шаардлагатай болсон гэсэн үг. Мөн хэрэглэгчийн мэдээлэл дутуу бол 131313 дугаарт баримт бүртгэгдэхгүй. Ebarimt.mn-д хэрэглэгчийн хувийн мэдээлэл дутуу болон алдаатай үед 131313 тусгай дугаараар баримт бүртгүүлэх боломжгүй ббболсон бөгөөд "Таны бүртгэл дутуу байгаа тул баримт бүртгэх боломжгүй" гэсэн мессэж тухайн иргэнд очиж байгаа. Үүнээс гадна хэрэв хэрэглэгчийн 131313 тусгай дугаарт төлбөрийн баримт бүртгүүлдэг гар утасны дугаар өөрчлөгдөх бол ebarimt.mn дэх бүртгэлтэй гар утасны дугаараа мөн өөрчилж, шинэ гар утасны дугаараа оруулах шаардлагатай. Иргэд 131313 тусгай дугаарыг ebarimt.mn системд хэрэглэгчийн хувийн мэдээлэл нь бүрэн хийгдсэн иргэд баримтаа бүртгүүлэх боломжтой, хэрэглэгчийн эрх авсан хувь хүн нууц үгээ мартсан тохиолдолд 131313 дугаар ? тэмдэг илгээж сэргээж авах боломжтой. Бусад тохиодолд 131313 дугаарын тусгай дугаарын утсыг ашиглахгүй. Мөн хэрэглэгчийн нэвтрэх код, нууц үгээ мартсан тохиолдолд хэрэглэгчийн мэдээлэлд бүртгэлтэй и-мэйл хаягаа ашиглан сэргээх боломжтой.

**-Хэрэглэгчийн нэвтрэх код, нууц үгээ сэргээхийн тулд яах ёстой вэ?**

-Хамгийн түрүүнд системд бүртгүүлсэн цахим шуудангаа оруулна. Уг цахим шуудан нь таны хүсэлтээр нэгдсэн системд бүртгүүлсэн и-мэйл хаяг байх ёстой. Дараа нь зурган код оруулах хэсэгт системээс санамсаргүйгээр харуулах үсэг болон тоон утгуудыг бөглөж оруулна. Хэрэв та уг зурган кодыг тайлж бичихэд хүндрэлтэй бол зурган кодын ар талд байрлах товчлуур дээр дарж зурган кодыг өөрчлөх боломжтой. Дээрх утгуудыг үнэн зөв оруулсан бол сэргээх товчийг дарах хэрэгтэй. Харин шинээр бүртгүүлэхдээ Е баримт цахим системд хувь хүн бүртгүүлэх хэсэгт орж, и-мэйл хаягаа бичиж зурган кодыг оруулна. Таны цахим шуудан руу системээс нууц үг сэргээх холбоос бүхий и-мэйл илгээх болно. Хэрэв зурган кодыг та буруу оруулсан бол системээс танд зурган кодыг буруу оруулсан тухай мэдэгдэл өгнө.

**-Сугалаанд мөнгө хожсон иргэдийн дансанд шууд орох уу. Эсвэл заавал бүртгүүлэх ёстой юу?**

-Сугалааны тохирлоор азтан болсон иргэд дараах хоёр үйлдлийг заавал хийх ёстой. Нэгдүгээрт, 500 мянган төгрөг хүртэл мөнгө хожсон иргэд ebarimt.mn системд тохирлын мэдээг баталгаажуулж, хүсэлтээ заавал илгээнэ. Хоёрдугаарт, 500 мянган төгрөгөөс дээш сугалааны хонжвор таарсан иргэд хүсэлтээ баталгаажуулж, орон нутгийн иргэд харьяа аймгийн татварын хэлтэст, Улаанбаатар хотын иргэд биеэр ТЕГ-ын Татварын орлогын газарт дараах материалыг авчирч өгөх ёстой. Ингэхдээ иргэний үнэмлэхийн хуулбар, иргэний үнэмлэхийн хамт, сугалаа таарсан баримт эх хувиар, хүсэлт/ebarimt.mn системээс татаж авна/, хонжворын баримтаа гээсэн тохиолдолд өргөдөл, сугалаа цэснээс хонжвор таарсан баримтын мэдээллийг хэвлэн хавсаргах хэрэгтэй.

МЭДЭЭЛЭЛ



## Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэхэд оюутнууд хамтарч ажиллана

Төлбөрийн чадваргүй яллагдагчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, тэдэнд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй төрийн байгууллага болох Хууль зүйн туслалцааны төв нь Шихихутуг Хууль зүйн их сургууль хамтран ажиллах санамж бичгийг өчигдөр үзэглэлээ. Санамж бичигт Хууль зүйн туслалцааны төвийн захирал Т.Уранболор, Шихихутуг их сургуулийн захирал Д.Оюунцэцэг нар гарын үсэг зурав. Санамж бичгийг үзэглэснээр төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг илүү хүртээмжтэй хүргэх, төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх замаар оюутныг дадлагажуулан хууль хэрэглэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, түүнчлэн иргэдэд хууль эрх зүйн мэдлэг олгох боломж нээгдэж буй юм.

## БОАЖЯ-аас сургуулиудад мод бэлэглэлээ

БОАЖ-ын сайд Д.Оюунхоролын ивээл дор JCI олон байгууллагаас сурагчдад ногоон боловсрол олгох зорилго бүхий "Нэг цэцэг нэг дэлхий", "Миний мод Монголын ирээдүй" төслүүдийг нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиуд болон цэцэрлэгүүдэд хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд Улаанбаатар хотын агаар, хөрсний бохирдол хамгийн ихтэй Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд ногоон төгөл байгуулах бөгөөд нийслэлийн 76 дугаар сургуулийн сурагчдад 200 цэцэг, 30 модны суулгац бэлэглэсэн. Энэ үеэр БОАЖЯ-ны Ойн бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн Ц.Бямбасүрэн "Салбарын яамнаас жил бүрийн хавар, намар бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулдаг уламжлалтай. Энэ хүрээнд нийслэлийн агаарын тоосжилтыг бууруулах нэн шаардлагатай орчинд ногоон төгөл байгуулах төсөл хэрэгжиж байгаад харахад таатай байна. Олон улсын байгууллагууд болон монгол залуусын санаачилгаар мод тарих хөдөлгөөн өрнүүлж байгааг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны зүгээс дэмжиж ирсэн" гээд тус сургуулийн сурагчдын тарьсан модыг намар ирж шалгана хэмээсэн юм. Төслийн хүрээнд нийслэлийн Сонгино-хайрхан дүүргийн 76, 67, 42, 106 дугаар сургууль болон 110 дугаар цэцэрлэгт үрсэлгээний мод, тасалгааны цэцэг бэлэглэж байгаа.

# ОНЦЛОХ ХУУДАС

# НЭР ХҮНД ЯАХ ВЭ, ҮР ХҮҮХДҮҮДЭЭ Л БОДЪЁ

## Эсрэг тэсрэг байр суурь

2017 оны гуравдугаар саны 27-нд 29 дүгээр сургуулийн 15 сурагч хичээл хаясан билээ. Тодруулбал, тус сургуулийн ахлах, дунд ангийн бүх сурагч хичээлдээ орохгүй байхаар шийдсэн бөгөөд тэд багш нар хичээлээ олигтой заахгүй, дохионы хэлээр биш амаар хичээлээ заадаг учраас ойлгодоггүй. Тиймээс бидний суралцах эрх зөрчигдөж байна. Мөн спортын янз бүрийн арга хэмжээнд хүүхдийг идэвхтэй оролцуулдаггүй, ялгавартай хандлаг төдийгүй хүүхдүүдтэй багш нар хүндэтгэлтэй бус харьцдаг гэсэн юм. Түүгээр ч барахгүй н.Доржпүрэв багш хүүхдийн толгой руу номоор байнга цохиж, өшиглөж, үснээс нь зулгаадаг гэж байв. Иймд тэд сурагчидтай хүндэтгэлтэй харилцах, дохионы хэл мэддэг багшаар хичээл заах, ялгаварлан гадуурхаж, хүчирхийлэх үйлдлээ зогсоохыг шаардсан. Харин энэ асуудал эцэс, төгсгөлгүй маргаан болж, хоёр тал болон хуваагдаад байгаа билээ. Тиймээс “Монголын мэдээ” сонин энэ удаагийн “Эсрэг тэсрэг байр суурь” булангаараа онцолж байна.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

### Б.Буян-Орших: Бид сонсохгүй ч гэсэн бүхнийг хардаг...

*/29 дүгээр сургуулийн 12А ангийн сурагч/*

-Бид хичээлээ дохиогоор сурмаар байна. Багш нар бидэнтэй үргэлж уурлаж харьцдаг, өмнө заасан зүйлсээ дахин дахин заадаг. Өмнө нь бид энэ асуудлыг сөхөх гэхэд багш нар “Одоо ойлголоо, битгий ингэ” гэж хэлж байсан. Бид гомдол гаргахаа болиод буцаад хичээлдээ явж л байсан. Одоо хангалттай. 29 дүгээр сургуулийн багш нар биднийг өрөвдөж, хайрлаач гэж гуйгаагүй. Зөвхөн багш нарын дохионы чадварыг сайжруулж өгөөч. Дохионы хэл дээр хичээлийг чадварлаг заадаг болох хэрэгтэй. Эрүүл хүүхдүүд яаж сурч байна, тэр хэмжээнд боловсролыг авдаг болмоор байна. Тэд зовж сурдаг бол бид ч гэсэн зовоод сурмаар байна. Бид сонсохгүй ч гэсэн харж байгаа шүү. Багш нар ажлын байран дээр ёс бус зүйлс хийдэг, бидэнд анхаарлаа хандуулахгүй байна. Бид сургуулиа төгсөөд ЭЕШ-д тэнцдэг бол өнөөдөр ийм асуудлыг гаргахгүй. Сургууль төгсөх болчихсон, амьдрал нүдэнд харагдаад эхэлчихсэн байхад одоо бачуурч байна.

### Б.Батсайхан: Багш нарыг чадваргүй гэж хэлж болохгүй

*/29 дүгээр сургуулийн захирал асан/*

-Багш нараа бид төрөл бүрээр сургаж, төр засгаас ч анхаарал тавьж байгаа. Тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр бэлтгэгдсэн багш Монголд алга байна. Тиймээс бид шалгаруулалтад тэнцсэн багш нарыгаа сургууль дээрээ дохионы хэлний хичээлд хамруулдаг. Багш нар чадваргүй, хичээл зүтгэл гаргадаггүй гэвэл би худлаа гэж бодож байна. Цаг үргэлж л хүүхдүүдийнхээ төлөө сурч боловсорч байдаг. Манай багш болгон тодорхой хэмжээний дохионы хэлний чадвартай. Хэн ч шалгаж, хэн ч тодорхойлоогүй учраас багш нарыг чадваргүй гэж хэлж болохгүй. Магадгүй энэ хүүхдүүдийн цаана хэн нэгэн зохион байгуулаад, хүүхдүүдийг ашиглаж байж болох юм. Хэрвээ хүүхдийг ийм зүйлд турхирч байгаа бол хариуцлага тооцох хэрэгтэй. Эцэг эх, багш нараараа дамжуулаад хэлж болохоор байхад өнөөдрийг хүртэл бичгээр гаргасан гомдол байхгүй.

### Б.Юмжирдулам: Энэ сурагчдыг битгий хэлмэгдүүлээрэй

*/1995 онд 29-р сургуулийг төгсөгч/*

-Чанартай боловсрол олгохгүй байна, хичээлийн цагийг үр дүнтэй ашиглаж чадахгүй байх шиг байна. Сургуулийнхаа багш нарыг ёс зүйн асуудал доголдолтой байгааг сурагчид нь хэлж байна. Тусгай сургуулийн сурагчид өмнөх үеийн төгсөгч нартай харьцуулахад их муу болж. Өнөөдөр би есдүгээр ангийн хүүхдээс “Энэ юу вэ?” гээд асуухад “Масло” гэдэг үгийг дохиогоор хэлж чадахгүй, мөс гэж хариулж байна. Гэтэл бидний үед хүүхдүүд ийм байгаагүй. Тухайн үеийн ахмад багш, сургуулийн удирдлагуудын хүүхдийг сургая гэсэн сэтгэл байсан учраас үр дүн гарсан. 1997 оны нэг үйл явдлыг эргэн сануулахад төгсөгчид нийлээд бичиг гаргаад яаманд өгч байсан. Яам энэ асуудлыг сонсоод, шийдвэрлэсэн боловч, тэр үед хөдөлгөөнд оролцоод, бичиг өгсөн хүүхдүүд маш их хэлмэгдсэн. Боловсролын системд өөрчлөлт хийгээч гэсэн хүсэлтийнх нь улмаас хавчиж, гадуурхсан жишээ бий. Наад зах нь одоо 29 дүгээр сургуулийн дотуур байранд ажиллаж байгаа н.Баярмаа багш. Бага ангийн багш мэргэжил эзэмшсэн боловч мэргэжлийнх нь дагуу ажиллуулахгүй, ямар сайндаа л дотуур байранд ажиллаж байна. Тиймээс одоо энэ хүүхдүүдийг өмнөх үе шиг битгий хэлмэгдүүлээсэй гэж хүсье.

### Т.Цэдэнбал: Г.Батбаяр өмгөөлөгч бидний эсрэг үйл ажиллагаагаа зогсоохгүй бол тэмцлээ хурц хэлбэрт шилжүүлнэ

*/“Монголын сонсголгүй иргэд” ТББ-ын тэргүүн/*

-Монгол Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах хууль 2010 онд батлагдсан. Энэ хуульд сонсголгүй хүний эх хэл дохионы хэл мөн гэж хүлээн зөвшөөрсөн. Би 29 дүгээр сургуулийг төгссөн. Одоогийн нөхцөл байдал ч мөн тухайн үед байсан. Олон жил тэвчсэн. 50 жилийн түүхт сургуулийг хараад сэтгэл их урагдаж байна. Хүүхдүүд дохионы хэлээр хичээл заа гэж хэлснийх нь төлөө өмгөөлөгч хөлслөн авч, 60 гаруй багшийг хүүхдүүдийн эсрэг турхирч буй маш муухай үйл явдал болж байна. Г.Батбаяр өмгөөлөгч өөрөө хууль бус үйл ажиллагаа явуулж байна. Сонсголгүй хүмүүсийг мэдэхгүй байж, мөнгөний төлөө сонсголгүй хүүхдийн эрх ашгийг хөндөж байна. Хүүхдүүдтэй ярилцахгүйгээр яагаад багш нарын эрх ашгийг хамгаалж байгаа юм бэ. 29 дүгээр сургуулийн захирлыг халаад энэ асуудал шийдэгдчих юм биш. Ирээдүйд 29 дүгээр сургуулийн захирлыг томилохдоо сонсголгүй хүний эрхийг давуу байлгахыг хүсч байна. Сонсголгүй хүний дуу хоолойг сонсох хэрэгтэй. Бидний төлөө үнэн сэтгэлээсээ ажиллах хүнийг томилно гэж бодож байна. Цаашид бидний эрх ашгийг хязгаарлахаа больцгоо. Бид сонсохгүй нь хамаагүй, бид бүгдийг мэдэж, бүгдийг харж байдаг. Бид мал биш. Хэрэв Г.Батбаяр өмгөөлөгч бидний эсрэг үйл ажиллагаагаа зогсоохгүй бол тэмцлээ хурц хэлбэрт шилжүүлнэ. Бид босох цаг ирсэн гэж бодож байна. Хүмүүстэй харилцахад хүүхдүүд маань дохионы хэлээ мэдэхгүй байна.

## Сэтгүүлчийн дүгнэлт

### АСУУДАЛ ШИЙДНЭ ГЭДЭГ ДАРГА ХАЛСНААР БОЛЧИХДОГ ЗҮЙЛ БИШ

Э.ТУУЛ

Орчлонд хүн болж төрсөн хэдий ч юу ч сонсохгүй, хайртай ээж, аавынхаа өхөөрдөн дуудахыг ч мэдэхгүй, хэзээ ч чимээ шуугианыг дуулахгүй, зөвхөн харж, дотроо төсөөлж явна гэдэг харамсалтай. Тэгэхдээ нэгэнт л төрөлхийн хэл яриа, сонсголын бэрхшээлтэй төрсөн хүүхдүүд үүнийгээ сөрөн зогсож, сурч боловсрохын төлөө хичээж буй. Гэтэл манай улсад хэл яриа, сонсголын бэрхшээлтэй төрсөн хүүхдүүдийн сурч, боловсрох, сургуулиа төгсөөд ажиллах орчин хамгийн муу байна. Ёстой “бор зүрхээрээ” гэдэг шиг тэд өөрсдийнхөө төлөө л зүтгэж байгаа гэхэд хилсдэхгүй. Үүнийг гэрчлэх гэсэн мэт, саяхан 29 дүгээр тусгай дунд сургуулийн сурагчид хичээл хаялт зарлаж, суралцах эрхийнхээ төлөө тэмцсэн. Тус сургуулийн 9, 10, 12 дугаар ангийн 30 гаруй сурагч, тэдний эцэг эхчүүд сурагчдын хичээлийг дохионы хэлээр заах, мэргэжлийн дохионы хэл эзэмшсэн багш нартай болохыг шаардсан.

Тухайн үед сурагчдыг уриа лоозон барьсан учраас жагсаал цуглаан зохион байгуулж байна гэж үзэн Сүхбаатар дүүргийн цагдаагийн газраас мэдэгдэл хүргүүлж, эсэргүүцлийн ажиллагааг зогсоож байв. Мөн сурах эрхийнхээ төлөө жагссан зарим сурагчдыг багш нар нь загнаж, хичээлд нь оруулаагүй тухай мэдээлэл цахим сүлжээнд цацагдсан. Эдүгээ бүр хоёр тал болж байгаад хэрэлдэж өгч байна. Тодруулбал, сонсголгүй иргэдийн эрхийг хамгаалах учиртай төрийн бус байгууллага, холбоод нэгдэн хүүхдүүдийн хүсэл, шаардлагыг сонсохыг уриалж буй. Харин нөгөө талд нь 29 дүгээр сургуулийн багш нар нэр хүндэд нь халдсан хэмээн хууль, хяналтын байгууллагад өргөдөл гомдол гаргаад явж байна.

Тэгвэл энэ асуудал яагаад үүсэх болов, хэчнээн жил энэ байгууллага ийм байдалтай байж байгаад өнөөдөр тэсрэв гэдгийг салбарын сайд нь, удирдах албан тушаалтнууд ухаж төнхөх учиртайсан. Гэтэл зүгээр л цахим орчин дахь дуулиан шуугианыг намжаах зорилгоор 29 дүгээр сургуулийн захирлыг халаад, асуудлыг намжаахыг оролдож байгаа нь эмгэнэлтэй. Сонсголгүйн боловсрол ТББ-ын тэргүүн А.Баасанжав “Сонсголгүй хүүхдийн үзэл бодол, хүсэл эрмэлзлэлийг хэн зохицуулах ёстой юм бэ? Албан ёсоор хэлмээр байна. Хүүхдүүдийг хэн ч турхираагүй. Хүүхдүүд боловсролоо сайн авч чадахгүй байна. Бид тэдгээр хүүхдүүдийн саналыг дэмжсэн. Би өөрөө сонсголгүй хүн. Бид хүн. Түүнээс сэтгэцийн өвчтэй хүн лав биш. Хавар болохоор сэтгэцийн өөрчлөлтөд ордог хүмүүс бид биш. Дохионы хэл хангалттай баялаг хэл. Энэ сонсголгүй хүүхдүүд ямар ч чадваргүй гэж хэлэхээ больцгоо. Тэдгээр хүүхдүүд маш их сурах хүсэлтэй байна” хэмээн хэлж байсан.

Тэгвэл боловсролын салбарынхан тэднийг хүн гэж харахгүй байгаад хамаг учир оршиж байгаа юм биш үү. Энэ асуудал дөнгөж одоо ч гараад байгаа юм биш. Бүр 20 жилийн өмнөөс л асуудал үүсээд, бүр идээлж, буглачихаад байхад яагаад хэн ч тоогоогүй юм бэ гэдгийг асууж, хариуцлага тооцох хэрэгтэй. Боловсролын салбар бол онцгой салбар, улстөрждөг, аль нэг намын юм уу, төрийн бодлогоор гарч ирсэн хүн удирдах ёсгүй. Цаашлаад тусгай сургуулийн хувьд мэргэжлийн өндөр чадвартай хүн удирдах ёстой. Яг үнэндээ сонсголгүй хүнийг ялгаварлан гадуурхаж байгаа нь өөрөө гэмт хэрэг. Тиймээс зөвхөн захирал халаад асуудал шийдэгдэнэ гэж бодож байгаа бол эндүүрэл шүү.

### Г.Батбаяр: Өнгөрсөн хугацаанд болж өнгөрсөн зүйлс тус сургуулийн нэр хүндэд халдсан хэрэг боллоо

*/Өмгөөлөгч/*

-Хэвлэлийнхэнд яриа өгсөн сурагчид олдохгүй байгаа. Үнэхээр тэдгээр хүүхдүүд хүчирхийлэлд өртсөн бол гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрт хамруулж, хамгаалалтад авах ёстой. “Ийгл Ньюс” телевизээр гарсан нэвтрүүлэгт яриа өгсөн сурагчдын дүрсийг нь бүрсийлгэж, дуу хоолойг нь өөрчилсөн байна билээ. Тиймээс 29 дүгээр сургуулийн багш нарын төлөөлөл цуглаж, Үндсэн хуулийн 16.12-т заагдсан төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдол гарган шийдвэрлүүлэх эрхтэй, түүнийг төрийн байгууллага шийдвэрлэх үүрэгтэй гэх хүрээнд хэвлэлийн хурал хийж байна.

Үнэхээр хүүхдүүдийг хүчирхийлдэг гэмт хэрэгтэн байгаа бол олж өгөөч. Мөн хохирогчийг нь тогтоогоод өгөөч гэдэг хүсэлтээ цагдаагийн байгууллагад гаргасан. Хэрвээ тийм этгээд байхгүй бол бид хэвийн ажиллаж, амьдрах эрхээ эдэлмээр байна гэдэг хүсэлт тавьсан. Хүүхдүүдийг хүчинддэг, зоддог, багш нар ажлын байран дээр хоорондоо бэлгийн харилцаанд оролцдог гэх доромжилсон, гүтгэсэн мэдээллийг эзэн холбогдогчгүй тараагаад байна. Уг мэдээллүүд нь ард иргэдийг төөрөгдүүлээд байна гэсэн гомдол гаргасан. Цөөн хэдэн хүүхдийн хийсэн жагсаалаас үүдэн эрхзүйн чадамжгүй эмэгтэй сурагчаас ярилцлага авч, эмэгтэй сурагчдад бэлгийн дарамт үзүүлж байсан гэх худал мэдээллийг тараасан байна. Сурагчдын ихэнх нь дотуур байранд амьдардаг. Тэдэнд бэлгийн дарамт үзүүлэх боломжгүй, эмч нарын үзлэгт хамрагддаг юм билээ. Мөн өнгөрсөн хугацаанд болж өнгөрсөн зүйлс тус сургуулийн нэр хүндэд халдсан хэрэг боллоо. Би маш олон сэтгүүлчдийг шүүхэд өмгөөлж байсан. Гэхдээ яг үнэндээ эх сурвалжаа нууцлах болон хэн нэгэнд мэдэгдэхгүй байх үүрэг хуулиараа зохицуулагдаагүй. Хэвлэлийн эрх чөлөөний хууль гэж дөрөвхөн заалттай жижигхэн хууль бий.

### Г.Оюун: Бидний нэр хүндэд халдаж байгаад эмзэглэж байна

*/29 дүгээр сургуулийн багш/*

-Бид хүүхдүүдийн шаардлагыг хүлээж авсан. Сургуулийн захиргаанаас “Хэн мэдээлэл өгөв” гэж асууж, шалгаагаагүй. Хэвлэл мэдээллээр цацагдаад байгаа бидний нэр хүндэд халгаатай мэдээллүүдийг шалгаж өгөөч ээ л гэдэг хүсэлтийг тавьж байна. Хавсарсан оноштой, оюуны хомсдолтой хүүхдүүд манай сургуульд байгаа. Гэхдээ бүх сурагчид тийм биш. Тэдгээр хүүхдүүд хичээл ном ойлгохдоо бусад хүүхдүүдийг бодвол өөр. Гэхдээ бид тэдгээр хүүхдүүдийг ялгаж харьцдаггүй. 12 дугаар ангийн хүүхдүүд ЭЕШ өгөөд дээд сургуульд орж байгаа. Манай сургуулийн сургалтын чанарыг шалгах газар нь шалгаад тогтоочихсон. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаад байгаа зүйлс манай сургуулийн багш нарын нэр хүндэд халдаад байна. Бид багш нарын дохионы хэлний чадвар болон сургалтын асуудлаар юм яриагүй. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурагчиддаа “бэлгийн дарамт” үзүүлж, тэднийг байнгын дарамт шахалтад байлгадаг гэх зүйлс яриад байна. Бид үүнд эмзэглэж байна. “Ийгл Ньюс” телевиз рүү шаардлага явуулсан нь үнэн. Гол нь манай сургуульд яг эдгээр асуудал байгаа эсэхийг шийдсэний дараа нэвтрүүлгээ олонд цац. Шийдээгүй байхад битгий олон нийтийг үймүүлээд бай гэдэг зүйлийг шаардлагадаа тусгасан.

# ДЭЛХИЙ

...Италийн эрх баригч Ардчилсан намын даргын сонгуульд эдүгээ 48 настай Хууль зүйн сайд Андреа Орландо, 57 настай мужийн захирагч Мишель Эмилиано нар өрсөлджээ...



# МАТТЕО РЕНЦИ

## ДАХИН ЕРӨНХИЙ САЙД БОЛЖ МАГАДГҮЙ НЬ

Б.ДАВАА

Италийн эрх баригч Ардчилсан нам өнгөрсөн сарын 30-нд дотооддоо намын даргын сонгууль явуулж, нийт намын гишүүдийн саналаар Маттео Ренциг дахин сонгожээ.

Тус улсад 2018 оны тавдугаар сарын 20-нд бүх нийтийн сонгууль болно. Улмаар энэ сонгуульд Ерөнхий сайд асан Маттео Ренци Ардчилсан намыг удирдан оролцохоор болж байна. Харин Ардчилсан нам олонх болсон тохиолдолд тэрбээр дахин Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэхээр болж байгаа юм.

Италийн эрх баригч Ардчилсан намын даргын сонгуульд эдүгээ 48 настай Хууль зүйн сайд Андреа Орландо, 57 настай мужийн захирагч Мишель Эмилиано нар өрсөлджээ. Ингээд санал хураалтын дүн гарахад, намын гишүүдийн 70 орчим хувь нь М.Ренцид итгэл хүлээлгэсэн байна. Үүний дараа тэрбээр ялалтаа зарлаж, "Шинэ түүх эхэллээ" гэжээ.

Намын даргын сонгуульд тодорхой шалгуурыг хангасан намын гишүүн бус хүн санал өгөхийг зөвшөөрдөг бөгөөд энэ удаад ойролцоогоор хоёр сая орчим хүн саналаа өгчээ.

Энэ үйл явдлаас таван сарын өмнө Маттео Ренци Ерөнхий сайдын суудлаасаа бууж байсан юм. Тэрбээр 1948 онд батлагдсан Үндсэн хуулийг шинэчлэх санаачилга гаргаж, бүх нийтийн санал асуулга явуулсан байдаг. Санал асуулгын мөн нэг чухал хүчин зүйл нь цаашид М.Ренци Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэх эсэхийг шийдвэрлэх байв.

Өөрөөр хэлбэл, санал асуулгаар иргэдийн ихэнх нь Үндсэн хуулийг шинэчлэх шаардлагатай гэж үзвэл Италийн парламентын дээд танхим болох Сенатыг өөрчилж, одоогийн 315 суудлыг 100 болгон бууруулж, хууль батлах эрх мэдлийг зөвлөх, санал гаргах хэмжээнд хүртэл хязгаарлаж нэг танхимаар хууль баталдаг системтэй болох байсан. Харин "Үгүй" гэсэн санал давамгайлбал Ерөнхий сайд Маттео Ренци албан тушаалаасаа огцрох байв. Гэвч, иргэдийн 60 орчим хувь нь "Үгүй", үлдсэн 40 хувь нь "тийм" гэсэн хариултыг сонгосон юм. Иймээс сонгуулийн үр дүн нэгэнт ойлгомжтой болмогц Италийн Ерөнхий сайд Ром хотод хэвлэлийн хурал зарлаж, ялагдлаа хүлээн зөвшөөрсний зэрэгцээ хариуцлагаа хүлээн албан тушаалаасаа огцорч буйгаа зарласан байдаг. Тэрбээр энэ үеэр "Засгийн газар дахь миний үүрэг хариуцлага үүгээр дууслаа" гэж хэлж байсныг тухайн үед орон нутгийн хэвлэлд мэдээлж байсан билээ.

Тэгвэл тэрхүү үйл явдлаас таван сарын дараа Ерөнхий сайд асан Маттео Ренци "Шинэ түүх эхэллээ" хэмээн ялалтаа зарлаж, Ардчилсан намыг ирэх сонгуульд удирдан оролцохоо мэдэгдэв. Цаашлаад ирэх оны сонгуульд түүний нам ялалт байгуулсан тохиолдолд дахин Ерөнхий сайд болж магадгүй нь.

## Д.Трамп Цагаан ордны уламжлалыг зөрчжээ

Цагаан ордны сэтгүүлчдийн холбооноос жил бүр зохион байгуулдаг оройн зоог барих арга хэмжээнд Д.Трамп хэвлэлийнхэн үнэн бодит мэдээ олон нийтэд хүргэдэггүй, хэний ч эрх ашгийг хамгаалах үүднээс худалдагдсан гуйвуулсан мэдээлэл тараадаг гэсэн үндэслэлээр оролцохоос татгалзсан байна. Энэхүү арга хэмжээ Вашингтоны ажил хэргийн төлөвлөгөөний томоохон арга хэмжээний нэгд тооцогдож, үе үеийн ерөнхийлөгч нар өндөр ач холбогдол өгсөөр ирсэн.

Уламжлал болсон энэхүү арга хэмжээнд оролгүй ерөнхийлөгч Доналд Трамп Пенсильваниа мужийн Харрисбург хотод ерөнхийлөгчийн албаны 100 дахь өдрөө хийсэн ажлаа тайлагнан өнгөрөөжээ. Харрисбург хотын үйлдвэрийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн үйлдвэртэй танилцаж, худалдааны хоёр ч төрлийн зарлигт гарын үсэг зуржээ.

Тэрбээр Харрисбург хотод хийсэн уулзалтынхаа үеэр "Холливудын жүжигчид болон сэтгүүлчид нийслэл Вашингтон хотын нэгэн зочид буудлын хүлээн авалтын танхимд яг одоо нэг нэгнийгээ магтан дэвэргэж, тал засан наргицгааж байгаа. Хэрвээ хэвлэл мэдээллийн байгууллагуудын үндсэн үүрэг нь шударга байж, үнэнийг мэдээлэх явдал мөн юм бол одоогийн байдлаар тэд маш муу дүн авахаар байна" гэж уг арга хэмжээнд оролцсон сэтгүүлчдийг шогложээ.

Ингэснээр Доналд Трамп Цагаан ордны чухал арга хэмжээнд тооцогддог энэхүү оройн зоогт 36 жилийн туршид оролцохоос татгалзсан анхны ерөнхийлөгч болж байна.

1981 онд Ерөнхийлөгч асан Роналд Рейган Цагаан ордны сэтгүүлчдийн холбооны оройн зоогт оролцоогүй бөгөөд тэрбээр амь насанд нь халдсаны улмаас эмнэлэгт эмчлүүлж байсан билээ. Харин ерөнхийлөгч асан Жимми Картер 1978, 1980 онуудад, 1974, 1972 онуудад хүндэтгэх шалтгааны улмаас оролцоогүй байдаг.

"The New York Times" сонины мэдээлснээр, 1924 оноос хойш сонгогдсон АНУ-ын төрийн тэргүүн нар сэтгүүлчдийн оройн зоог барих арга хэмжээнд уг албан тушаалыг хаших хугацаандаа наад зах нь нэг удаа оролцож, үг хэлсэн байдаг аж. АНУ-ын Ерөнхийлөгч асан Барак Обама уг арга хэмжээнд найман удаа оролцож байжээ.

## Жан-Мари Ле Пен охиноо дэмжив



Францын Ерөнхийлөгчийн сонгуулийн шийдвэрлэх шатны сонгууль энэ сарын 7-нд болох билээ. Уг сонгуульд глобалчлал болон хэт либералчлалыг дэмжигч, ЕХ-нд Францыг үлдээнэ гэдгээ амлаад буй Эдийн засгийн сайд асан 39 настай Эммануэль Макрон, "Үндэсний фронт" намын дарга 48 настай Марин Ле Пен нар тунаж үлдсэн. Тэдний хэн нь ч сонгуульд ялсан үр дүн нь түүхэн байх юм. Банкир мэргэжилтэй, эдүгээг хүртэл нэг ч удаа сонгуульд өрсөлдөж байсан туршлагагүй Э.Макрон сурталчилгаагаа 12 сарын өмнө эхлүүлж байсан удаатай. Хэрэв тэрбээр энэ удаагийн сонгуульд ялалт байгуулбал Францын түүхэн дэх хамгийн залуу ерөнхийлөгч болох юм. Гэхдээ сүүлийн үеийн санал асуулгуудад Макрон тэргүүлсэн үзүүлэлттэй байгаа нь Франц түүхэндээ анх удаагаа 39 настай Ерөнхийлөгчтэй болох магадлалыг өндөрсгөж байна. Театрын урлаг, яруу найрагт дуртай Макрон ахлах сургуулийнхаа театрын багш Брижитт Трогнекстай гэр бүл болсон байдаг. Тэр нь ч сонгууль дөхсөн эл өдрүүдэд дуулиант мэдээллийн нэг болж байгаа юм. Ирээдүйд тэргүүн хатагтай болох магадлал өндөр гэгдэж буй Брижит нөхрөөсөө 25 насаар эгч төдийгүй, гурван дагавар хүүхэдтэй. 2007 онд Макронтой гэрлэсэн. Харин "Үндэсний фронт" намын нэр дэвшигч Марин Ле Пен шийдвэрлэх шатны сонгуульд ялалт байгуулбал Францын түүхэн дэх анхны эмэгтэй Ерөнхийлөгч болох юм. Түүний хувьд Макроноос удам дагасан улстөрч гэдгээрээ ялгарна. Марин Ле Пены эцэг Жан Мари Ле Пен 2002 онд Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөж байжээ. Тухайн үед шийдвэрлэх шатны сонгуульд тунаж үлдсэн ч, эцсийн мөчид ялагдаж байсан гэнэ. Түүний хувьд хоёр удаа гэрлэсэн бөгөөд гурван хүүхэдтэй. Гэхдээ хувийн амьдралаа тэр бүр олонд дэлгээд байдаггүй аж. Түүнчлэн, Жан-Мари Ле Пен



өөрийн охин болох "Үндэсний фронт" намын тэргүүн Марин Ле Пен Францын Ерөнхийлөгчийн сонгуулийн хоёрдугаар шатанд ялна гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлээд амжсан байна. Тэрбээр "Би түүний явуулж буй сонгууль кампанит ажлын явцыг ажигласан. Тэрбээр тун шийдвэртэй, зоригтой байна. Түүний кампанит ажлыг би "ядуусын кампанит ажил" гэж нэрлэмээр байна. Тийм учраас миний охин сонгуулийн хоёрдугаар шатанд ялах магадлал илүү байгаа юм. Түүний гол үүрэг бол Франц орон болон францчуудыг аврах явдал билээ" гэж ярьжээ. Өдөр бүр явуулж буй олон нийтийн санал асуулгын дүнг харвал, Э.Макроныг сонгогчдын 60 хувь нь дэмжиж байгаа бол Марин Ле Пений төлөө 40 хувь нь саналаа өгөхөд бэлэн байна.

## Мүүн Жэ Ин санал асуулгад тэргүүлж эхэллээ

БНСУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль болоход долоо хоног үлдлээ. Тэгвэл хамгийн сүүлийн үеийн санал асуулгыг Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшиж буй Мүүн Жэ Ин бусдаасаа илт давуугаар тэргүүлж эхэлжээ. БНСУ-ын хувийн хэвшлийн судалгааны байгууллага "real meter"-ын өнгөрсөн сарын 27-29-ний өдрүүдэд явуулсан санал асуулгад Мүүн Жэ Ин 42.6 хувийн саналаар тэргүүлсэн байна. Энэ дүнг өмнөх санал асуулгатай харьцуулж үзвэл түүнийг дэмжигчдийн хувьд 1.8-аар буурчээ. Харин хоёрдугаарт Ардын намаас нэр дэвшигч Ан Чёл Сү 20.9 хувийн саналаар бичигдсэн байна.

Энэ удаагийн сонгуулийн гол өрсөлдөөн Ардын нам болон Ардчилсан намаас нэр дэвшигчдийн хооронд өрнөнө гэдгийг ажиглагчид онцолж байгаа. Тэгвэл хамгийн сүүлийн санал асуулгад тэдний дэмжигчдийн хувь асар зөрүүтэй болж ирсэн нь анхаарал татаж эхэлжээ. Сонгууль болоход ердөө долоо хоногийн хугацаа үлдээд байхад өнгөрсөн удаагийн Ерөнхийлөгчийн сонгуульд Пак Гын Хед ялагдаж байсан Ардчилсан намын нэр дэвшигч Мүүн Жэ Ин олон нийтийн санал асуулгыг тэргүүлсээр байна.

## БНХАУ-ын С919 онгоц тун удахгүй анхны нислэгээ хийнэ




Хятадын арилжааны нисэх онгоцны корпорацийн (CO-MAC) ерөнхий менежер Хе Дун Фенг өнгөрсөн сарын 27-нд Шанхайд нээгдсэн Европын Иргэний нисэхийн аюулгүй байдлын анхдугаар симпозиум оролцжээ. Энэ үеэр БНХАУ-ын үндэсний үйлдвэрлэлийн "C919" загварын зорчигч тээврийн онгоц тун удахгүй анхны нислэгээ хийх гэж буйг зарласан байна. Тэрбээр "БНХАУ-ын бүтээсэн зорчигч тээврийн онгоц эдүгээг хүртэл аль хэдийнэ доогуур, дундуур, өндөрт нисэх туршилтыг 21 удаа хэрэгжүүлсэн. Одоо анхны нислэгээ үйлдэхэд бэлэн болсон" гэж хэлжээ. Мөн "C919" зогчигч тээврийн онгоц яг хэзээ анхны нислэгээ хийх талаар тодорхой хариулт өгөөгүй байна. Гэхдээ "Онгоц болон багийн гишүүдийн байдал, бас цаг агаар таатай өдөр хийх байх" гэж хариулсан аж. 2008 онд байгуулагдсан COMAC одоогоор гол гурван төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй бөгөөд орон нутгийн зорчигч тээврийн ARJ21 онгоц нь аль хэдийнэ 413 захиалга авчихсан. Харин тун удахгүй анхны нислэгээ үйлдэх гэж буй том оврын нисэх онгоц C919-ыг 570 ширхэгийн захиалга аль хэдийнэ компанид иржээ. C919 нь 158 зорчигчийн суудалтай, хэвийн горимд 4075 км, дээд тал нь 5555 километр нисэх чадвартай юм. 2008 онд Хятадын арилжааны нисэх онгоцны корпораци буюу COMAC-ийг 2.7 тэрбум ам.долларын хөрөнгөтэйгөөр үүсгэн байгуулж байжээ. Улмаар 200 гаруй компани, хэдэн мянган эрдэмтнийхээ оюуныг шав¬хан байж анхны хөлгөө үйлдвэрлэсэн нь C919 юм.

Түүнчлэн, хөгжүүлэлт хийж эхэлсэн widebody онгоц нь 280 хүний суудалтай, 12 мянган км зам туулах хүчин чадалтай гэнэ.

## АНУ БНХАУ-д буулт хийхэд бэлэн

АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп өчигдөр "CBS" телевизэд ярилцлага өгчээ. Энэ үеэр Солонгосын хойгт үүссэн хурцадмал байдлыг шийдвэрлэхэд БНХАУ АНУ-тай хамтарч ажилласан тохиолдолд гадаад худалдааны бодлогодоо буулт хийхэд бэлэн байгаагаа илэрхийлсэн аж. Тэрбээр ярилцлагын үеэр АНУ-ын аюулгүй байдал худалдааны ашгаас илүү эрхэм гэдгийг онцолж байсан гэнэ. Д.Трамп "БНАСАУ-ын цөмийн хөтөлбөртэй холбоотой хурцадмал байдлыг намжаахад БНХАУ хамтран ажиллавал тэр нь манай улсын хувьд муу худалдааны гэрээтэй дүйнэ" гэдгийг тодотгосон байна. Мөн "Худалдаа туйлын чухал. Гэхдээ нэг сая гаруй хүн үхэж болзошгүй томоохон дайнаас зайлсхийх нь түүнээс илүү чухал" гэсэн байна.

Д.Трамп БНХАУ-ыг АНУ-ын зах зээл дээр өөрийн бүтээгдэхүүний үнэд давуу байдал үүсгэх зорилгоор валютын ханшаа удирддаг хэмээн шүүмжилдэг билээ.

# ЦАГ ҮЕ

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Н.БАТЗАЯА

*МУБИС-ийн Эрдэм шинжилгээ хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал, Техник-технологийн улсын олимпиадыг зохион байгуулах дэд хорооны дарга, доктор профессор Л.Цэрэнсодномтой ярилцлаа.*

**-Улсын техник, технологийн XXI олимпиад өнгөрсөн амралтын өдрүүдэд болсон гэсэн. Олимпиад хэр амжилттай болж өндөрлөв. Энэ талаар мэдээлэл өгөхгүй юу?**

-Монгол Улсын хэмжээнд нийт 12 олимпиадыг зохион байгуулахыг зөвшөөрдөг. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын хэмжээнд 12 төрлийн хичээлээр олимпиад зохион байгуулагддаг гэсэн үг. Энэ дундаас хамгийн олон төрөлд олон сурагч, багш өрсөлддөг гэдгээрээ техник, технологийн олимпиад өндөр ач холбогдолтой байдаг. XXI



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# Л.Цэрэнсодном: МОНГОЛ ХҮҮХДҮҮД ДЭЛХИЙН ХЭМЖЭЭНИЙ ЗАГВАР БҮТЭЭЖ, ӨРСӨЛДДӨГ

удаагийн техник, технологийн олимпиад өнгөрсөн дөрөвдүгээр сарын 25-28-ны хооронд олон улсын Найрамдал төвд амжилттай болж өндөрлөлөө. Энэ удаагийн олимпиадад хөдөө орон нутаг болон нийслэлийн есөн дүүргээс шалгарсан нийт 262 багш сурагч оролцсон. Тодруулбал, аймаг, нийслэлээс шалгарсан шилдэг 180 сурагч, 82 багш ур ухаан, мэдлэг чадвараараа өрсөлдлөө. Манай олимпиад нийт есөн төрөлд зохион байгуулагддагаараа онцлогтой. Авто дуураймал загвар, нисэх онгоцны загвар, усан онгоцны загварын тэмцээн, дүрслэх урлаг, дизайны багш нарын тэмцээн, дүрслэх урлаг, дизайны сурагчдын тэмцээн гэх зэрэг нийт есөн төрөлд болдог. Энэ жилийн техник, технологийн улсын олимпиадад багийн дүнгээр I байрт Улаанбаатар, II байрт Увс аймаг, III байрт Орхон аймаг, IV байрт Хөвсгөл аймаг, V байрт Сэлэнгэ аймгийн оролцогчид шалгарсан.

**-Техник технологийн нэг онцлогнь олон төрлөөр явагддаг гэлээ. Өөр ямар онцлогтой вэ. Сурагчдыг хөгжүүлэхэд өндөр ач холбогдолтой байх?**

-Манай олимпиадын нэг онцлог нь гэвэл тухайн хүүхдээс бүх төрлийн хичээлийн мэдэгдэхүүнийг шаарддаг. Нисэх онгоц болон усан онгоцны загвар хийхэд математик, физик, электроникийн талаар мэдлэгтэй байх ёстой. Эдгээр мэдлэгийг тодорхой хэмжээнд эзэмшиж байж нисэх онгоцны загвар бүтээдэг. Түүнээс гадна тухайн хүүхдээс маш их хичээл зүтгэл, хөдөлмөр шаарддаг. Яагаад гэвэл нисэх онгоцны загвар бүтээсэн хүүхэд байлаа гэж бодоход бүтэн жилийн хөдөлмөрийн үр шимээ авч ирж уралдаанд оролцдог. Мэдлэгийн хажуугаар ур чадварыг ч шаарддаг онцлогтой. Мөн 21 жилийн хугацаанд зохион байгуулагдсан энэхүү олимпиадад оролцож байсан хүүхдүүд дунд их, дээд сургууль төгсөж, дээд мэргэжил эзэмшсэн Монголын тэргүүлэх зэргийн компанийн захирлууд олон байна. Тухайлбал, Мобиком, Скайтел компанийн Ерөнхий захирлууд манай олимпиадад оролцож байсан. Ер нь техник, технологийн олимпиадад аливаа зүйлсийг хийх сонирхолтой, дуртай хүүхдүүд л орно. Автомашины загвар зохион бүтээхийг хүүхэд бүр сонирхохгүй шүү дээ. Ганцхан түүнд дуртай, бүх цаг заваа дуртай зүйлдээ зориулдаг хүүхэд л сонирхоно. Яагаад гэвэл нэг загвар гаргахад өдөржин, шөнөжин суух юу ч биш байдаг. Түүнээс ч урт хугацаанд суух нь бий. Хүнээс их хөдөлмөр шаарддаг.

...Олимпиадыг амжилттай явуулахад нийт 28 сая төгрөгийн зардал шаардлагатай. Харин улсаас 11 сая төгрөг өгдөг. Үлдсэн 10 гаруй сая төгрөгийг ивээн тэтгэгчийн тусламжтайгаар олдог. Ивээн тэтгэгчид нь мөн л манай сургуулийг төгссөн залуучууд байдаг. Санхүүгийн хувьд бор зүрхээрээ л явдаг. Зохион байгуулах хорооны гишүүдэд нэг төгрөгний ч шагнал байдаггүй. Бид "Найрамдал" төвд олимпиадаа зохион байгуулдаг нь олон төрлийн ач холбогдолтой...

**-Техник технологийн олимпиадыг анх зохион байгуулсан цагаас нь эхлэн эдүгээг хүртэл тасралтгүй Зохион байгуулах хорооны даргаар ажилласан гэсэн. Ер нь техник, технологийн анхны олимпиад хэрхэн болж байв. Тэр үеийн дурсамжаасаа хуваалцахгүй юу?**

-Техник, технологийн олимпиад зохион байгуулагдах болсон түүх их сонин л доо. Манай улсад бүх хичээлийн төрөлд улсын хэмжээний олимпиадууд зохиогддог ч ганцхан техник, технологийн чиглэлд зохиогддоггүй байсан юм. Харин энэ орон зайг МУБИС-ийн төгсөгч, "Залуу монгол" корпорацийн захирал н.Чимэдцэрэн харж, анх санал дэвшүүлсэн. 1998 онд "Техник, технологийн улсын олимпиадыг зохион байгуулъя. Би ивээн тэтгэе" гэдэг санал хэлсэн. Тухай үед улсын олимпиад ивээн тэтгэгчдийн тусламжтайгаар явагддаг байлаа. Улсаас мөнгө өгдөггүй байсан юм. Энэ саналын дагуу н.Чимэдцэрэнгийн санаачилга, хөрөнгө оруулалтаар Монгол Улсын техник, технологийн олимпиад анх удаа зохион байгуулагдсан түүхтэй. Эхний 10-аад жил "Залуу монгол" корпораци болон техник, технологид сонирхолтой хүмүүс ивээн тэтгэсэн. Сүүлийн 10 жилд улсын олимпиадыг БСШУСЯ-аас ивээн тэтгэж, тодорхой хэмжээний санхүүжилт гаргадаг болсон.

**-Анхны олимпиадад сурагчид хэр идэвхтэй оролцож байв?**

-Эхний хэдэн жилд Залуу техникчдийн ордон, хотын цөөн хүүхэд оролцдог байлаа. Хөдөө орон нутгийн сурагчид оролцоход тун хэцүү. Учир нь усан болон нисэх онгоц хийхэд их материал ордог. Шаардлагатай материалууд нь хөдөө орон нутагт олддоггүй байсан үе. Тухайлбал, нисэх онгоцны загвар бүтээхэд далавч хийдэг тусгай технологи шаардлагатай. Түүнийг авч чадахгүйгээс болж эхний ээлжинд хөдөө орон нутгаас цөөхөн хүүхэд оролцсон. Харин одоо бүх аймгийн сурагчид оролцох болсон. Олимпиадын цар хүрээ жигдэрсэн. Олимпиадаас эхний гурван байр эзэлсэн хүүхэд их сургуульд дөрвөн жил үнэ төлбөргүй суралцах боломжтой учраас оролцогчдын ур чадвар сайжирч, хүчтэй өрсөлдөх болсон.

**-XXI жилийн хугацаанд олимпиадад оролцож буй хүүхдүүдийн ур чадвар, мэдлэг хэрхэн өөрчлөгдөж байна вэ?**

-20 жилийн өмнөхийг энэ цаг үетэй харьцуулахад огт өөр шүү дээ. Одоо үед гар утас, робокон бий болсон. Мэдээ, мэдээлэл, техник, технологийн өндөр дэвшилд хүрсэн. Тиймээс бид олимпиадынхаа шалгуурыг улам боловсронгуй болгохын тулд сүүлийн үеийн мэдээлэл, технологийн талаархи асуултыг олимпиадын материалдаа оруулж байна. Ер нь бид цаг үетэйгээ холбогдуулан олимпиадын даалгавраа боловсруулдаг. Олимпиадад оролцож буй хүүхдүүдийн оюун санаа маш их өөрчлөгдсөн. Гаргаж буй загвар хийцнээс нь харахад, сэтгэлгээ нь тэлсэн харагддаг. Дээхэн үед манай олимпиадад оролцсон хүүхдийн бүтээсэн онгоцны загварыг одоо оролцож буй хүүхдийн бүтээсэн загвартай харьцуулахад тэнгэр, газар шиг ялгаатай. Сурагчид олимпиаддаа дэлхийн хэмжээнд өрсөлдөхүйц бүтээлээр оролцож байна. Аймаг бүр ач холбогдол өгч оролцдог учраас өрсөлдөөн өндөр түвшинд хүрсэн.

**-Техник, технологийн олимпиадад тэргүүн байр эзэлсэн сурагчид их сургуульд суралцаж, төгссөний дараа тэдэнд тохирох ажлын байр байна уу?**

-Усан онгоцны загвар хийдэг хүүхэд тэр төрлийн мэргэжлийг эзэмших бус ихэвчлэн инженерийн чиглэлээр суралцдаг. Манай улсад усан онгоцны инженерийн орон тоо байхгүй. Гэхдээ цөөн тооны зарим залуучууд гадаадад ажилладаг. Тухайлбал, усан онгоцны чиглэлээр БНХАУ-д суралцаж, гадаадад ажилладаг залуус бий. Харин эх орондоо автомашины чиглэлээр суралцах боломжтой. Техник, технологийн олимпиадаас хүүхдүүд инженер, техникийн анхан шатны мэдэгдэхүүн авч байгаа учраас энэ чиглэлээр ихэнх нь суралцдаг.

**-Одоогийн байдлаар хэчнээн хүүхдэд үнэ төлбөргүй хүссэн их дээд сургуульдаа элсэн суралцах эрхийг олгоод байна вэ?**

-Жил бүр есөн төрөлд тус бүр эхний гурван байрт хүссэн их, дээд сургуульдаа элсэн суралцах эрхийг олгодог. Үүнээс харахад нийт 567 хүүхдэд хүссэн сургуульдаа суралцах эрхийн бичиг өгсөн байна. Энэ жил шагналын нөхцөлд тодорхой хэмжээний өөрчлөлт гарсан. Өмнө нь жил бүр 27 хүүхдийн дөрвөн жилийн сургалтын Төлбөрийг улсаас гаргадаг байсан. энэ жилээс тухайн сургууль нь тодорхой хэмжээний хөнгөлөлт үзүүлдэг байхаар тогтлоо.

**-Шүүгчдийн бүрэлдэхүүнд 22 хүнээс бүрддэг гэлээ. Ямар хүмүүс шүүгчдийн бүрэлдэхүүнд ажиллаж байна вэ?**

-Ихэвчлэн их сургуулийн багш нар шүүгчдийн бүрэлдэхүүнд ордог. Тухайлбал, дүрслэх урлагийн төрлийг манай сургуулийн дүрслэх урлагийн шинжлэх ухааны доктор, профессор н.Эрдэнэцог багш шүүдэг. Техникийн их сургуулийн багш нар шүүгчдийн бүрэлдэхүүнд ордог. Нисэх загварын төрлийг нисэх загварын "Масса" нийгэмлэгийн гишүүд ирж шүүдэг. Шүүгчдийн хувьд тухайн чиглэлээр мэргэшсэн хүмүүс байх шаардлагатай байдаг.

**-Нисэх онгоцны загвар зохион бүтээх гэдэг нэг төрлийн спорт болсон. Хөдөө орон нутагт энэ чиглэлийг хөгжүүлэхэд хэр анхаарч ажиллаж байна вэ?**

-Цэдэнбал Пелетава Залуу техникчдийн ордонг байгуулсан түүхтэй. Энэ ордон хөдөө орон нутагт салбартай байсан. Харамсалтай нь 1990 онд Залуу техникчдийн ордон хувьчлагдаж, улмаар хөдөө орон нутаг дахь салбар нь татан буугдсан. Харин одоо нисэх болон автомашины загвар зохион бүтээх салбар хөгжих гол үндэс нь ерөнхий болосвролын сургуулийн технологийн багш нар болсон. Өөрөөр хэлбэл, сургуулийнхаа технологийн кабинетэд л зохион бүтээх ажлаа хийж байна. Өнгөрсөн жил залуу техникчдийн ордонг сэргээх асуудал яригдсан. Сайд үйл ажиллагааг нь сэргээх тушаал гаргасан ч сайн хэрэгжээгүй. Залуу зохион бүтээгчдийн үйл ажиллагааг дэмжих зорилготой Залуу техникчдийн ордон устчихсан. Энэ бол ганцхан жишээ. Ер нь 1990 оноос хойш хүүхэдтэй холбоотой бүх л зүйлс устсан шүү дээ.

**-Зохион байгуулах хорооны хувьд олимпиадаа тасралтгүй уламжлал болгон явуулахад хүндрэлтэй зүйлс гардаг байх. Санхүү мөнгөнөөс эхлээд олон зүйл байгаа болов уу?**

-БСШУС-ын сайдын тушаалаар жил бүр зохион байгуулах хорооны гишүүдийг томилдог. Манай хороонд ихэвчлэн есөн хүний бүрэлдэхүүнтэй байдаг. Техник, технологийн олимпиадыг зохион байгуулахад хүндрэлтэй зүйлс олон гарна. Улсаас нийслэлийн нэг багшийн хоолны зардалд 5000 төгрөг, хөдөө орон нутгийн нэг багшид 12 мянган төгрөг олгодог. Гэтэл бид улсын техник, технологийн олимпиадыг Найрамдал төвд зохион байгуулахад, нэг хүнд дунджаар 50 мянга гаруй төгрөг шаардлагатай. Олимпиадыг амжилттай явуулахад нийт 28 сая төгрөгийн зардал шаардлагатай. Харин улсаас 11 сая төгрөг өгдөг. Үлдсэн 10 гаруй сая төгрөгийг ивээн тэтгэгчийн тусламжтайгаар олдог. Ивээн тэтгэгчид нь мөн л манай сургуулийг төгссөн залуучууд байдаг. Санхүүгийн хувьд бор зүрхээрээ л явдаг. Зохион байгуулах хорооны гишүүдэд нэг төгрөгний ч шагнал байдаггүй. Бид "Найрамдал" төвд олимпиадаа зохион байгуулдаг нь олон төрлийн ач холбогдолтой. Тухайлбал, нисэх онгоц уралдах зам талбай, усан онгоцны усан сан, оролцогчдын байрлах байр, хоол хүнс гэх мэтчилэн олон зүйлс нэг дор төвлөрдөг. Түүнээс гадна сурагчид болон багш нар олон улсын "Найрамдал" зусланг үзэх боломж бүрддэг. Олимпиадад оролцохоор ирсэн багш, сурагчдын дунд "Найрамдал" зусланг анх удаа үзэж буй хүн ч байдаг. "Найрамдал" зуслан бол Монгол хүүхэд бүрийн очиж үзэхийг хүсдэг газар шүү дээ. Энэ утгаараа сурагчдыг "Найрамдал" зусланд хоёр хоног ч болтугай амраахыг боддог. Манай сургууль "Найрамдал" төвтэй хамтын ажиллагаатай. Энэ хүрээнд олимпиадын дутуу үлдсэн мөнгөн дүнгийн оронд манай сургуулийн оюутнууд бүтээл хийж өгдөг. Жишээлбэл, Харшийн ёолкны хувцсыг манай сургуулийн дизайны ангийн оюутнууд урладаг. Тайз чимэглэлийн ажлыг Технологийн ангийн оюутнууд хийдэг.

**-Олимпиадад оролцсон зарим сурагчдад гадаадын томоохон компаниас санал тавьж байсан гэж сонссон. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?**

-Өнгөрсөн жил Монгол дахь "Тоёото" корпорацийн төлөөлөгчид манай олимпиадыг ирж сонирхсон юм. Энэ хүрээнд автомашины дуураймал загвар зохион бүтээх төрөлд оролцож буй бүх хүүхэд компанийнхаа гарын бэлэг өгсөн. Тэд "Гайхамшигтай ур чадвартай хүүхдүүд Монгол Улсад олон байдаг юм байна" хэмээн гайхаж байсан. Түүнээс өмнө Японы том корпорацийн эзэн манай олимпиадыг сонирхсон. Тэр үед нэг япон машины радио засч чадахгүй байсан юм билээ. Гэтэл манай олимпиадад оролцож байсан нэг сурагч радиог нь засчихсан. Түүнийг харсан япон захирал "Алс холын Япон улсын машины радиог монгол хүүхэд засварлана гэдэг сонирхолтой юм. Би энэ хүүхдийг Япон улсад сургая. Манай компаниас сургалтын зардлыг бүрэн хариуцна" гэж байсан удаатай. Ер нь техник, техологийн улсын олимпиадад оролцож буй хүүхдүүдийг ямар нэгэн улсад авч сургах сонирхолтой хүн олон бий. Япон, Солонгос, ОХУ-ын техник, технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд хүртэл танай хүүхдүүдээс авч сургая, олимпиадыг чинь ивээн тэтгэе гэх зэрэг санал тавьдаг. Энэ мэтчилэн гадаадад суралцаж, тэндээ ажиллаж байгаа залуучууд ч бий. Харин олимпиадыг ямар нэгэн компанийн нэрэмжит болгох талаар бид хүлээн зөвшөөрдөггүй. Учир нь энэ бол улсын олимпиад. Ямар нэгэн компанитай хамтарч зохион байгуулахаар тухайн компанийн сонирхол давамгайлах тал өндөр байдаг. Тиймээс бид олимпиадаа шударга явуулахын тулд энэ саналд тийм ч таатай ханддаггүй.

**-Хүүхэд, залуучууд техник, технологийн салбарыг сонирхож, хичээллэснээр улс орны хөгжилд ямар ач холбогдолтой юм бэ?**

-Улс орны хөгжил инженер, техникийн ажилтнуудын ур чадвар, мэдлэг боловсролтой хамаатай. Манай улсад олон том үүрэн телефоны корпорациуд бий. Эдгээр корпораци амжилттай ажиллахад боловсон хүчин чухал. Техникийн сэтгэхүйтэй, авьяастай хүмүүс байх шаардлагатай. Харин эдгээр хүмүүсийг хөгжүүлэхэд, техник, технологийн олимпиад маш их үүрэг гүйцэтгэж байгаа. Авьяастай хүүхдүүдийг хөгжүүлэх үйл ажиллагаа олимпиадын хүрээнд явагддаг. Тухайн хүүхэд автомашины загвараа хийж л хөгжинө. Техник, технологийн бодлого бодож л хөгжинө. Түүний үр дүнд эхний гурван байрт шалгарсан сурагчдыг их, дээд сургуульд үнэ төлбөргүй сургадаг нь ирээдүйн чанартай боловсон хүчин бэлтгэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүнийг иргэд тэр бүр анзаарахгүй л дээ. Гэтэл Монголын хамгийн шилдэг инженер, техникийн ажилчид техник, технологийн олимпиадад

NO STRESS

ХҮРХРЭЭ ЛИГ



# Х.Цагаанбаатараар ахлуулсан “Цагаан барс” илүү байлаа

Э.ТУУЛ

Улсын хэмжээнд зохиогдож буй спортын тэмцээн, уралдаануудаас хамгийн өндөр шагналын сантайд зүй ёсоор тооцогддог “Хүрхрээ” үндэсний дээд лигийн шинэ улирал эхэллээ. “Хүрхрээ” үндэсний дээд лигийн шинэ улиралд 10 багийн 200 гаруй тоглогч, 11 улсын 39 легионер тамирчин өрсөлдөх бөгөөд дээд лигийн түүхэнд хамгийн өндөр буюу 120 сая төгрөгийн шагналын сантай юм.

Үндэсний дээд лигийн ерөнхий спонсороор Монголын хөлбөмбөгийн холбооны албан ёсны түнш үндэсний тодотголтой “Алтан Жолоо” групп, Хүнсний манлай үйлдвэр “Арвайн Үндэс” компани “Хүрхрээ” брэнд гурав дахь жилдээ хамтран ажиллаж байна. “Хүрхрээ” лигийн нээлтийн үйл ажиллагааны нэгэн сонирхол татсан үйл явдал нь хөлбөмбөгийн ногоон талбайд Монголын урлаг, спортын алдартнуудаас бүрдсэн “Цагаан барс”,”Хөх чононууд” багуудын тоглолт байлаа. “Цагаан барс”-ыг Хөдөлмөрийн баатар, олимпын аварга Н.Түвшинбаяр ахласан бол “Хөх чононууд” МУСГЗ Ш.Гүрбазараар ахлуулсан байсан юм. Тэмцээний нээлтийн өмнөх сорил тэмцээнд багууд эн тэнцүүхэн өрсөлдөж, 4:4-өөр тоглолт өндөрлөсөн. Харин шинэ улирлын нээлтийн үеэр “Цагаан барс” илүүрхсэн юм.

Тоглолтын эхний гоолыг Олимпийн хүрэл медальт, дэлхийн аварга Х.Цагаанбаатар оруулж, 500 мянган төгрөгийн эзэн болсон бол “Цагаан барс” баг хожлыг авч таван сая төгрөгийн шагнал гардан авсан. Харин хоёр дахь гоолыг “Цагаан барс” багийн гишүүн, “Guys” хамтлагийн дуучин Д.Лхагва оруулснаар тэмцээнийг 2:0-ээр тэргүүлж, таван сая төгрөгийн шагналыг багтаа авчирсан юм. Түүнчлэн тус тоглолтыг үзсэн 1300 үзэгчийн тасалбараас олсон 1000 төгрөг бүрийг Монголын хөлбөмбөгийн холбооныхон “Аутизмыг таниулах сарын аян”-д зориулж, нийгэмд тустай үйл хийв. Мөн Монголын охидын шигшээ багийн тоглогчид тус аяныг таниулах алхаанд оролцлоо.

Ийнхүү бүтэн улирлын турш үргэлжлэх Хүрхрээ үндэсний дээд лигийн шинэ улирал эхэллээ. Хөлбөмбөгийн үнэнч фанатууд,хөгжөөн дэмжигчид ээ, Хүрхрээ үндэсний дээд лигээ үзэж Монголынхоо хөлбөмбөгчдийг дэмжицгээе.







ДУУЛГАХ СОНИН



## Боксынхон есөн медаль хүртлээ

ОХУ-ын Борзя хотод тус улсын боксын сургуулийг үндэслэгч Ю.Н.Саранины нэрэмжит сонирхогчдын боксын өсвөр үеийнхний олон улсын тэмцээн боллоо. Тус тэмцээнд гавьяат дасгалжуулагч Ё.Төмөрбатаа, “Талын бүргэд” клубын дасгалжуулагч Т.Эрдэнэбаярын удирдлага дор оролцсон манай ширэн бээлийтнүүд гялалзсан амжилт байгуулав. Тухайлбал хөвгүүдийн 50 кг-д Ч.Ууганхүү, 52 кг-д О.Өнөболд, 64 кг-д Б.Отгонбат, 69 кг-д Э.Бат-Өлзий нар алтан медаль хүртсэн бол охидоос 50 кг-д Н.Даваадэлгэр алтан медаль хүртлээ. Мөн 49 кг-д Э.Мөнхтөр, 40 кг-д О.Тэмүүжин мөнгөн медаль хүртсэн бол 38 кг-д Г.Болд-Эрдэнэ, О.Баттөр хүрэл медалийн тавцанд зогссон байна. Энэ тэмцээнд ОХУ, Монгол, БНХАУ-ын нийт 141 тамирчин өрсөлдсөнөөс манай баг тамирчид таван алт, хоёр мөнгө, хоёр хүрэл медаль хүртсэн амжилтаар багийн дүнг тэргүүллээ.

ОДДЫН АМЬДРАЛ

## Бейонсе тэтгэлэгт хөтөлбөр зарлажээ

АНУ-ын алдарт дуучин Бейонсе “lemonade” цомгоо гаргаснаас хойшхи нэг жилийн ойг тохиолдуулан эмэгтэй оюутнуудад зориулсан тэтгэлэгт хөтөлбөр зарлажээ. Зоригтой, бүтээлч, өөртөө итгэлтэй, сурч боловсрох чин хүсэлтэй залуу эмэгтэйчүүдэд уг тэтгэлгийг олгох гэнэ. Охид, эмэгтэйчүүд тэтгэлэгт хамрагдсанаар Беркли хөгжмийн их сургууль, Харвардын их сургууль, Парсонсын урлагийн их сургууль, Спелманы их сургуулиудад үнэ төлбөргүй суралцах боломжтой аж. Гэхдээ эдгээр сургуулиудад 2017-2018 оны хичээлийн жилд зөвхөн нэг эмэгтэйг л сонгох юм байна. Мөн шинээр элссэн оюутнууд, сурч байгаа, төгссөн оюутнууд, урлаг, хөгжим, Африк гаралтай америк хүмүүстэй холбоотой судалгаа хийж буй хүмүүс хамрагдах боломжтой.

## Жонни Депп далайн дээрэмчний дүрд хувирчээ



Жүжигчин Жонни Депп АНУ-ын Калифорни мужид байрлах “Дисней ланд” паркт “Карибын тэнгисийн дээрэмчин” цуврал киноны Жак Спарроу далайн дээрэмчний дүрд хувиран ирж, тэнд хүрэлцэн ирсэн үзэгчдийг баясгажээ. Жонни Депп ахмад Спарроугийн хувцас өмсч, киноны алдартай хэсэг болох шатнаас буунгаа чинжаал хутга эргүүлэх хөдөлгөөнийг хийж, үзэгчидтэй ярилцах зэргээр шүтэн бишрэгчиддээ гэнэтийн бэлэг барьсан байна. Дашрамд дурьдахад, түүний тоглосон “Карибын тэнгисийн дээрэмчин” киноны шинэ цуврал “Карибын тэнгисийн дээрэмчин: Үхсэн хүн үг хэлэхгүй” кино энэ сард АНУ-д нээлтээ хийх билээ. Уг киног Диснейтэй хамтран бүтээсэн гэнэ.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 8
Шөнө 1

Нөгөөдөр
Өдөр 4
Шөнө -5

Өдрийн зурхай

**ХАВРЫН АДАГ ХӨХ ЛУУ САРЫН ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ҮХЭР ӨДӨР**

**Үс засуулбал:** Хэл ам,хэрүүл тэмцэл ирнэ.

**Наран ургах, шингэх:** 05.37-20.06



*Тухайн өдөр могой жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба бич, гахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр худалдаа арилжаа хийх, бизнэс эхлэх, хүү сангийн эх хатгах, эд агуурс авах, зээл авах, арвижуулах, дэлгэрүүлэх үйлийг эхлэх, угаал үйлдэх, мал арилжих, гэр бүрэхэд сайн. Улааны үйлд муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.*

Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд

Ганбат Г.



Найз минь харж явдаг охинтойгоо уулзаад хоёр, гурван цаг алхсан юм байх. Хүний урманд түй ч дуугарахгүй яваад л байж, яваад л байж. Тэгээд охины гэрийн гадаа очтол охин инээгээд “За би орлоо” гээд алхаж л дээ. Тэгсэн мань хүн араас нь дуудсанаа “Юу байна” гэсэн гэж байгаа. Цррррр тэр хоёр одоо суух гэж байгаа. Дараагийн паянг нь бичих гэсэн чинь инээд хүрээд болдоггүй ээ. Хэ хэ хэ


ТЭНГИС







Нэгэн эмэгтэй Дом-г хүчээр гэмт хэрэгт татан оролцуулж хамгийн дотно хүмүүсийнх нь эсрэг ажиллуулна. Гэр бүл шиг болсон тэд урьд өмнө учирч байгаагүй сорилттой тулгарна.

Аймшигтай ослоос амь гарсан бүсгүйг төгс чадвартай киборг болгон өөрчилж компьютерийн хакеруудын бүлэглэлийн эсрэг илгээнэ.



